МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ”

Судалгааны төрөл: **Нөлөөллийн судалгаа**
Судалгааны код: **БГСТ-24/021**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Даймонд лекс партнерс ХХК

Улаанбаатар хот
2024 он

ГАРЧИГ

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
2. ХУРААНГУЙ
3. ОНОЛЫН ХЭСЭГ
    a. Эдийн засгийн өсөлтийн онолууд
    b. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай
4. СУДАЛГААНЫ ХЭСЭГ
    a. Гадны хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал
    b. ДНБ болон ГШХО-ын харилцан хамаарал
    c. Гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадвар
    d. Гадаадын хөрөнгө оруулалт буурах шалтгаан
    e. Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт
5. ГУРАВДУГААР БҮЛЭГ
    a. Heritage foundation economic freedom index
    b. Milken institute Attracting Foreign Index
    c. UNCTAD дэлхийн хөрөнгө оруулалтын чиг хандлага
    d. Сингипур улсын ГШХО-ын бодлого
6. ДҮГНЭЛТ

© Даймонд лекс хуулийн этгээд
Уг судалгааг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу! Мөн нийтлэл болон судалгаанд ашиглахдаа эх сурвалжийг заавал дурьдана уу.
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Эрхи төв, 9 давхарт.
Утас: 86128866
e-mail; by.enkhzaya@gmail.com

Судалгааг Парламентын сургалт, судалгааны Даймонд лекс ХХК бодлогын судлаачид хийж гүйцэтгэв.

Судалгааг хийж гүйцэтгэсэн:
Судалгааны багийн ахлагч: Г.Должинсүрэн
Судлаачид: Б.Энхзаяа, Н.Хасар
Хянасан: Г.Должинсүрэн

Судалгааны дүгнэлт, санаа, үзэл баримтлал нь гагцхүү судалгааны багийнх бөгөөд Даймонд лекс ХХК болон бусад захиалагч байгууллагуудынх бус болно.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

ХУРААНГУЙ

Судалгааны үндэслэл

Монгол улс зүүн хойд азид орших Европ, Азийг холбосон, хойд талаараа ОХУ, урд талаараа БНХАУлстай хиллэж, 3 сая гаруй хүн амтай ардчилсан улс юм.

Монгол улс 1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр гадаадын хөрөнгө оруулалт татах эрх зүйн болон улс төрийн засаглал бий болсон гэж үзэж болно. Анхны гадаадын хөрөнгө оруулалтын журам 1990 онд батлагдаж тухайн жилдээ 0,96 сая ам.доллар байсан бол 2011 онд 4,9 тэрбум ам.долларт хүрч даруй 4,9 мянга дахин өссөн үзүүлэлт юм. Энэ хэрээр Монгол улсын дэлхийд эдийн засгийн өсөлтийн хурдаараа тэргүүлж ДНБ-ний өсөлт жилийн 17,5%-д хүрсэн юм. Гэсэн хэдий ч 2011 оноос гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурч 2015 оны байдлаар -82,5%-д хүрээд байна.

2017 оноос Гадаадын шууд хөрөнгө оруулалт эргэн өсөж эхэлж буй боловч Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын хувьд 82.5% нь уул уурхайн салбарт байгаа нь бусад эдийн засгийн салбаруудын хувьд үр ашиг багатай байна. Энэ нь уул уурхайн салбар дахь БНХАУ-ын эрэлт эрс нэмэгдсэнтэй шууд холбон үзэж болох талтай болно.

Судалгааны ажлаар Гадаадын шууд хөрөнгө оруулалтын эдийн засаг дахь нөлөөлөх нөлөөллийг судлах, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтын шалтгаан зэргийг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Улс төр болон иргэдийн зүгээс гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой сөрөг мэдээлэл, буруу ойлголтоос үүдэн гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашиг зөрчигдөх, энэ хэрээр эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөх, энэ нь эргээд иргэдийн аж амьдралд нөлөөлж буй учир бодит мэдээлэл өгөх, гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ний өсөлт, эдийн засгийн өсөлттэй шууд хамаарал байгаа эсэхийг судлахыг зорьлоо.

Судалгааны ажлын бүтэц.

Судалгааны ажил гурван бүлэг, хураангуй, дүгнэлт зөвлөмж, ашигласан материал зэргээс бүрдэж байна.

Нэгдүгээр бүлэгт гадаадын шууд хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж буй эсэхийг тодорхойлохын тулд эдийн засгийн өсөлтийн онолууд болон гадаадын хөрөнгө оруулалтын онолуудыг авч үзсэн.

Хоёрдугаар бүлэгт Монгол улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлыг эмпирик аргаар судалсан болно.

Гуравдугаар бүлэгт олон улсын индексүүд болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн өсөлтөө хангаж дэлхийд тэргүүлж буй Сингапур улсын туршлага, кэйсийг судалсан болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

Нэр томъёоны тодорхойлолт:

Эдийн засгийн өсөлт. Эдийн засгийн өсөлтийг нилээд өргөн хэрэглэгдэж байгаа дараах хоёр тодорхойлолтоор хэмждэг.

- Ашиглагдаж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тоо хэмжээг нэмэгдүүлсний буюу техник технологийг боловсронгуй болгосны үр дүнд үндэсний нийт бүтээгдэхүүн / ҮНБ /-ний хэмжээнд гарах бодит өөрчлөлтөөр
- Нэг хүн амд ногдох бодит орлогын хэмжээ нэмэгдэх буюу ҮНБ-ний бодит хэмжээ өсөх үйл явцаар

$$\text{Эдийн засгийн өсөлтийн хурдац} = = \frac{(\text{Тухайн орны ҮНБ}) * 100\%}{\text{Суурь оны ҮНБ}}$$

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн. Улс орны тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг Дотоодын Нийт Бүтээгдэхүүн гэдэг бөгөөд тухайн орны үйлдвэрлэх хүчний нөөцөөр нэг жил үйлдвэрлэж бий болгосон материал баялагийн өртгөөр илэрхийлдэг. Нийт бүтээгдэхүүнийг хүн амд хуваавал нэг хүнд ногдох хэмжээ гарна. Үүгээр улс орны хөгжлийн болон амьдралын түвшинг тооцоолдог. Нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний өсөлт нь улс орны хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл юм.

- Улс орны дотооддоо тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг **“Дотоодын Нийт Бүтээгдэхүүн”** гэдэг бөгөөд тухайн орны үйлдвэрлэх хүнчний нөөцөөр нэг жилд үйлдвэрлэж бий болгосон материал баялагийн хэмжээг зах зээлийн өртгөөр илэрхийлдэг. Нийт бүтээгдэхүүнийг хүн амд хуваавал нэг хүнд ногдох хэмжээ гарна. Үүгээр улс орны хөгжлийн болон амьдралын түвшинг тооцоолдог. Нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний өсөлт нь улс орны хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл юм.
- ДНБ дээр тухайн улсын иргэдийн гадаад дахь хөрөнгө оруулалтаас олох орлогыг нэмбэл **Үндэсний Нийт Бүтээгдэхүүн** (ҮНБ) гарна.
- Үндэсний Нийт Бүтээгдэхүүнээс (ҮНБ) капиталын элэгдлийн шимтгэлийг хасвал **Үндэсний Цэвэр Бүтээгдэхүүн** гарна.
- Дотоодын Ний Бүтээгдэхүүнээс шимтгэлийг хасвал **Дотоодын Цэвэр Бүтээгдэхүүн** (ДЦБ)гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс шимтгэл ба шууд биш татваруудыг хасвал цэвэр орлогуудын нийлбэр буюу **Үндэсний Орлого** (ҮО) гарна.

Хүний хөгжлийн индекс

Хүний хөгжлийн индексийг иргэдийнх нь дундаж наслалт, боловсрол (насанд хүрсэн хүн амын бичиг үсэг тайлагдсан байдал, бүх нийтийн боловсролд хамрагдсан байдал), бодит орлого (нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, худалдан авах чадвараар хэмжигдэх амьдралын түвшин) гэсэн үндсэн гурван хэмжүүрийг ашиглан тооцож байна. Эдгээр хэмжүүрүүд нь тус бүртээ өөрийн индекстэй бөгөөд тухайн улсын дундаж наслалт нь 85, нэг хүнд ногдох ДНБ 40 мянган ам.доллар, насанд хүрсэн бүх хүн уншиж, бичиж чаддаг, хүүхэд багачууд нь бүх шатны сургуульд 100 хувь хамрагддаг бол 1 оноо авах юм. Хүний хөгжлийн идексийг гаргаснаар хувь хүний

амьдралын түвшинг дээшлүүлж, нийгмийн бүх салбарт хөгжиж боловсрох боломжийг бий болгох арга хэмжээ авахад ашигладаг байна.

- Боловсролын индексийг насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдал, бага, дунд, дээд боловсролд хамрагдсанааг тэгээс нэг хүртэлх оноогоор хэмжиж байгаа бөгөөд 0,9-өөс дээш оноо авах нь боловсролтой, хөгжилтэй улсыг илэрхийлдэг байна. Хүн амын боловсролын түвшний индексээр хамгийн өндөр нь Австрали улс (0.973), Норвеги улс (0.989) тэргүүлж байна.
- Дундаж наслалт өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн хувьд хүчирхэг бөгөөд иргэд нь өрсөлдөх чадвар хамгийн өндөр байдгийг үздэг байна. Дэлхийд дундаж наслалтаар хамгийн өндөр үзүүлэлттэй нь Япон улс 0.973 (82.7 жил) байна.
- Дотоодын Нийт Бүтээгдэхүүнийг Дэлхийн банкны системээр эдийн засгийн бүх орлогыг тооцох болон хэрэглээ, үйлчилгээ, экспорт зэргээр бүх зардлаар нь тооцдог байна. Дэлхийн банкны тооцоогоор нэг иргэнд 11.9 мянган ам.доллараас дээш мөнгөн дүн ногдож байвал өндөр орлоготой, 3,8 мянгаас 11,9 мянган ам.доллар бол дундаас дээгүүр орлоготой, 976-3,8 мянган ам.доллар бол дунд зэргийн, 975 ам доллараас доош орлоготой бол буурай оронд тооцогддог байна. Энэ үзүүлэлтээр АНУ тэргүүлж, хамгийн өндөр нь байгаа бөгөөд Япон улс удаалсан байна.

Эдийн засгийн өсөлтийн онолуудын талаар товчхон

Улс орны эдийн засгийн өсөлтийн судалгаанд онолын хувьд энэ асуудлыг хэрхэн авч үздэгийг товч боловч хөндөх нь зүйтэй. Аливаа онол, үзэл баримтлал, тэр тусмаа нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, ихэд түгэн тархсан онол нь амьдрал дээр тодорхой хэмжээнд шалгагдсан, зарим талаар нотлогдсон байдаг.

Эдийн засгийн өсөлтийн тхай гурван гол онолыг нэн тэргүүн авч үзэх нь чухал.

Нэгдүгээрт. Шинэ сонгодог онол.

Үндэслэгч нь Robert Solow (1956). Энэ онол ёсоор эдийн засгийн өсөлт нь үр ашигтай зардлыг нэмэгдүүлж, технологийг сайжруулсны үр дүн гэж үздэг. Энэ онол ёсоор биет хөрөнгө оруулалт болон хүний капиталыг эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл гэж үздэг.

Хоёрдугаарт. Газар зүйн болон байршлын онол. Энэхүү онолыг дэлгэрүүлэгч нь Jeffrey Sachs болон түүний хамтран зүтгэгчид юм. (Sachs 2001, Gallup, Sachs and Mellinger 1998, Diamond 1997) Энэ онол ёсоор цаг уурын нөхцөл болон гол зах зээлд ойрхон байдлыг өсөлтийн анхдагч хүчин зүйлүүд гэж үздэг. Тухайлбал, халуун орны уур амьсгал нь ажиллагсдын ажиллах чадварт муугаар нөлөөлж, хөдөлмөрийн чадваргүй тахир дутуу болох мадер гэх мэт халуун орны өвчнөөр өвдөх магадлалыг нэмэгдүүлдэг. Цаг уурын ийм нөхцөл нь ажиллагсдын бүтээмжийг бууруулж бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг сайн татаж чаддаггүй. Үүний эсрэг гол зах зээлд ойрхон, далайд гарцтай байх нь бизнесийн үйл ажиллагааг идэвхижүүлэх нөлөө үзүүлдэг гэж үздэг.

Гуравдугаарт. Институтчилэгдэх онол.

Гол төлөөлөгчид нь Douglass Cecil North (1990), Peter Bauer (1957, 1972), Friedrich Hayek (1945, 1960). Энэ онол ёсоор улс төрийнн нөхцөл болон институтчилэлийг бий болгож өгөх нь эдийн засгийн өсөлтөнд маш чухал гэж үздэг. Сүүлийн үед энэ онолоор

Barro (1996), Barro болон Sala Martin (1995), Scully (1988, 1992), Landes (1998), Knack (1996, 2003), Desoto (1989), Mall болон Jones (1999) нар бичиж улам гүнзгийрүүлэн өөрсдийн хувь нэмрийг оруулсан байдаг.

Эдгээр онолууд нь логикын хувьд бие биедээ зөрчилддөггүй учир бүгд л эдийн засгийн өсөлтөнд нөлөөтэй хүчин зүйлүүдийг авч үзсэн байдаг.

Үүнээс гадна эдийн засгийн өсөлтийгн “ортогдос” буюу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн онол байдаг. Уг онолыг дэлгэрүүлэн хөгжүүлсэн хүмүүс нь Johansen, Meade, Phelps, Samuelson, Solow, Swan, Tobin, von Weizsacker, Vaari нар бөгөөд өмнөх үеийн Domar, Harrod, Hicks, Robinson нарын үзэл санааг үргэлжлүүлэн хөгжүүлсэн болно. Энэхүү онол нь бодит байдалд нилээд ойртсон, эдийн засгийн өсөлт бүтээмжийн олон жилийн динамик судалгаа, математик загварт үндэслэсэн маш олон хүчин зүйлийг хамруулан авч үздэг онол юм. Тухайлбал, урт хугацаанд техникийн дэвшил нь хөрөнгийн зардалтай харьцуулвал эдийн засгийн өсөлтийн чухал нөхцөл гэж үздэг. Үүний зэрэгцээ дээд боловсрол, эрдэм шинжилгээний судалгааны зардал, өндөр технологитой үйлдвэрлэл нь өсөлтийн нэг чухал хүчин зүйл гэж үзжээ.

Эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх хүчин зүйлс

Онолын хувьд улс орны эдийн засгийн өсөлтөнд олон хүчин зүйлс нөлөөлдгийг дээр бид авч үзсэн. Эдгээрээс эдийн засгийн өсөлтийн шинжилгээнд ажиллах хүч, капиталын хэмжээ, хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтийг гол хүчин зүйлс болгон ихэвчлэн судалдаг.

Эдийн засгийн өсөлтөнд ажиллах хүч, капиталын хэмжээ хэрхэн нөлөөлснийг тооцохыг судалгааны бүтээлүүдэд “Өсөлтийн тооцоо” (Growth Accounting) буюу манай оронд үйлдвэрлэлийн функцээр тооцох гэдэг. Энэхүү аргаар эдийн засгийн өсөлт бий болоход ажиллах хүч болон капитал ямар хувь нэмэр оруулсныг шинжилдэг. Эдийн засгийн өсөлтөнд үзүүлсэн дээрх хүчин зүйлсийн хамаарлыг үйлдвэрлэлийн агрегат функциар илэрхийлдэг.

$$Y_1 = A_t K^{\alpha}_t L^{\beta}_t$$

Энд: Y_1 – ДНБ, A_t – бүтээмжийн хүчин зүйл, K^{α}_t – Капиталын хэмжээ, L^{β}_t - ажиллах хүчний хэмжээ.

Энэхүү үйлдвэрлэлийн агрегат функц нь t – гэсэн хугацаанд үйлдвэрлэлийн 2 хүчин зүйл болох капитал, ажиллах хүчийг бүтээмжийн нэгдсэн хүчин зүйл (А) болгон нэгтгэн үйлдвэрлэлийн эцсийн үр дүн болох ДНБ-тэй холбож өгдөг. Энд А гэсэн коэфциент нь капитал, ажиллах хүчээр үл тайлбарлагдах бусад хүчин зүйлийн нөлөөг илэрхийлдэг бөгөөд энэ нь технологийн дэвшил, нийт бүтээмжийн нөлөө гэж үздэг.

Манай орны хувьд ажиллах хүчний хэмжээг нийт ажиллагсдын тоогоор хялбархан илэрхийлж болдог бол харин капиталын хэмжээг харуулсан мэдээлэл байдаггүйгээс өөр үзүүлэлтээр орлуулан тооцоход хүрдэг. Энэхүү судалгаанд капиталын хэмжээг ДНБ-ийн тооцоонд орсон үндсэн капиталын хэрэглээ болох үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөнгө оруулалт хоёрын аль нэгнээр орлуулан авах арга байсан. Гэвч үндсэн хөрөнгийн элэгдлийн үндсэн капиталын орлуулан авахад гарсан үр дүн статистикийн хувьд ач холбогдол багатай гарсан тул хөрөнгө оруулалтыг орлуулан авлаа. Уг нь тухайн жилийн хөрөнгө оруулалтын ихэнх нь үндсэн хөрөнгө болон хувирдаг гэсэн агуулгаар үндсэн капиталыг орлуулсан боловч өмнөх үеүдэд хуримтлагдсан капиталын хэмжээг тусгаагүй тул учир дутагдалтай нь мэдээж билээ.

Бид энэхүү судалгаанд дараах өгөгдлүүдийг ашиглав. Үүнд:

Y_1 – ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр

I – Нийт хөрөнгө оруулалт, 2005 оны зэрэгцүүлэх үнээр / сая.төг /, t=1990-2009

L – Ажиллагчдын тоо, /мянган хүн/

Хөрөнгө оруулалтыг 2005 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ барилгын салбарын нэмэгдэл өртгийг 2005 оны үнэд шилжүүлсэн дефляторыг ашиглав.

Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функцыг шугаман хэлбэрт оруулан хувиргахад:

$$LogY=A+\alpha\cdot LogI+\beta\cdot LogL \text{ болдог.}$$

ХОЁР. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

IMF-аас эрхлэн гаргадаг сэтгүүлд “Хөрөнгө оруулагч өөрөөсөө өөр эдийн засгийн орчинд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн менежментийн үйл ажиллагаанд өөрийн дуу хоолойгоо гаргах зорилгоор хийж буй хөрөнгө оруулалтыг хэлнэ” гэж тодорхойлжээ.

“Хөрөнгө оруулагч эдийн засгийн өөр орчин дахь аж ахуйн нэгжтэй урт хугацааны туршид харилцан, түүний үйл ажиллагаанд тасралтгүй ашиг сонирхол үзүүлэн, шууд хяналт тавьдаг хэлбэрийг хөрөнгө оруулалт гэж UNCTAD World Investment Report-д тодорхойлжээ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагаас хэрэгжүүлж буй Олон талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрт гадаадын хөрөнгө оруулалтыг “биет болон биет бус хөрөнгө гадаад орноос дотоодод орж ирээд зогсохгүй баялагийг бий болгох зорилготой үйл ажиллагаанд оролцох үйл явц” гэж тодорхойлсон байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай онолууд:

Грехэмийн онол /Graham Theory/: Грехэм нь олон улсын эдийн засагт солбилцсон хөрөнгө оруулалтын шинэ хандлагыг анх илрүүлжээ. Америк болон Европын пүүсүүд зарим олигополистик аж үйлдвэрийн салбарт солбилцсон шинжтэй хөрөнгө оруулалт хийж байна. Энэ нь тэдний өрсөлдөгчийн түрэмгий, тухайлбал үнээ огцом бууруулах зэрэг хариу хамгаалалт хийх үүднээс хөрөнгө оруулалт хийдэг байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын макро түвшний онол

1950-иад оны сүүл үеэс капиталын зах зээлийн онол буюу капитал байгаа орон руу нь хөрөнгөө оруулснаар ашгаа ихэсгэнэ гэсэн санаа бүхий онол нь хамгийн эртний онолуудын нэг бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт нь хүүгийн түвшнээр тодорхойлогдоно. Гэвч энэ нь капиталын урсгал хоёр талт урсгалаар явагддаг шалтгаан, олон улсын худалдаа зах зээлээр бус пүүсээр зохион байгуулагддагийн учир, үндэстэн дамнасан компаниуд оршин байгаа, пүүс яагаад үндэснийхээ хил даван гардгийг тайлбарладаггүй. ыг онолоос гадна үндэстэн дамнасан корпорацийн стратегийн урт хугацааны үүргийн нэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалт бөгөөд хөрөнгө оруулалтын хугацаа нь макро эдийн засгийн орчны өөрчлөлтөөс хамаарна гэж үзээд “хоцролт”ын нөлөөг тайлбарласан Динамик макро эдийн засгийн гадаадын шууд хөрөнгө оруулалтын онол болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал ба валютын түвшний өөрчлөлтийн харилцан холбоог шинжилж гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ханшийн өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах хэрэгсэл гэж үздэг.

Ханшийн түвшинд үндэслэсэн онол гарч байжээ.

Түүнчлэн олон улсын үйлдвэрлэлийн багцыг үүсгэхэд нөлөөлдөг хүчин зүйлийг судлах, шинэ санаа шинэчлэл нь хөрөнгө оруулалтын шалтгаан болдог. Грета Гарбогийн /Greta Garbo/ нөлөө гэсэн санаа бүхий Эдийн засгийн газарзүйд үндэслэсэн онол, ъатах хүчний онол буюу эдийн засаг, газарзүй, соёлын хувьд ойрхон хоёр улсын хувьд хөрөнгө

оруулалтын урсгал өндөр байна гэсэн үзэл, Институцийн шинжилгээнд үндэслэсэн онол буюу гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалд институцын бүтцийн ач холбогдлыг судладаг, улс төрийн тогтвортой байдал нь гол үзүүлэлт болдог гэсэн баримтлал бүхий онолууд боловсруулагдсан байдаг.

Эдгээр онолууд болон бусад үзэл санаанууд дээр үндэслэгдэн дараагийн боловсруулагдсан онолууд нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тайлбарлахад илүү дөхөм байдаг.

Боломжийн онол: Энэ онолыг анх 1984 онд Стефен Мэги /Stephen Magee/ дэвшүүлсэн ба уг онолын гол санаа нь пүүс өөрийн давуу талаас илүү боломжит үр ашиг олохын тулд хамтын хөрөнгө оруулалт хийхээс 100 хувийн хөрөнгө оруулалт хийж дангаар хяналт тогтоож бизнесийн нууцаа хадгалах боломжтой. Хэрэв пүүс тухайн улсад /хөрөнгө оруулж буй улс/ өөрийн гадаад түншдээ нууцаа хуваалцвал тэр мэдлэг нь хожим түүний эсрэг ашиглагдах боломжтой. Гэхдээ нууц гэгдэх мэдээлэл /мэдлэг/ нь патентаар хамгаалагдсан байвал уг нууц мэдлэгээс боломжит ашиг олох болоцоогүй юм. Өөрөөр хэлбэл уг онолын цаад санаа нь бизнесийн тухайн нууцаа хөрөнгө оруулагч дангаараа эзэмших, эзэмшиж байж бизнес үйл ажиллагаагаа баталгаатай явуулах боломжтой юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хөгжлийн онол - бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн онол (Raymond Vernon. 1966)

Олон улсын бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн онол: Олон улсын бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн онол нь гадаадын хөрөнгө оруулалт бол бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн нэгэн ердийн үе гэж тайлбарладаг. Бусад пүүсүүд ижил төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд борлуулахад компаниуд зах зээлээ алдахаас сэргийлэхийн тулд хилийн чанад дахь үйлдвэрт хөрөнгө оруулалтыг хийдэг бөгөөд зарим нь экспортын зах зээлийг хайдаг.

Амьдралын мөчлөгийн онолыг шаймонд Вернон дэлхийн 2-р дайны дараагаас Ахыын үндэстэн дамнасан корпорацийн өргөжилтийг тайлбарлахын тулд боловсруулсан. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хийж буй пүүсүүд нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн тодорхой шатанд хийнэ гэж үзсэн.

Бүтээгдэхүүн боловсруулалт ба стандартчилалд хүрч бүтээгдэхүүний зардал чухал асуудал болох үед гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдэнэ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ингэснээр гадны болон дотоодын өрсөлдөгчдийн эсрэг пүүс өрсөлдөөний байршлыг олж авах хамгаалалтын хэрэгсэл болдогыг онолоор шинэ бүтээгдэхүүн анх бий болоод экспортлогч орноос импортлогч орон руу шилждэг. Олонх бүтээгдэхүүнд динамик өөрчлөлт ажиглагдсан ч энэ таамаглал нь тогтмол хэвээр байна. Жишээ нь, томпьютер анх Ахы-д / Apple, IBM / боловсруулагдаад гадаад зах зээлд экспортлогдсон. Компьютер стандартчлагдах үед АНУ нь Япон, Солонгос, Тайваньд үндэслэгдсэн үйлдвэрлэгчдийн импортлогч болсон. Экспортлогчдод эдгээр улсуудад байршсан АНУ-ын компаний салбарууд болох гадаадын пүүсүүдийг багтана.

Уг онол нь АНУ-ын жишээн дээр үндэслэгдсэн ба 1950 болон 1960-д оны үеийн үйлдвэрлэл, экспортын хамаарлын тайлбар болж байжээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нисч буй галуун цувааны онол(Kojima Ozawa 1984)

Өнгөрсөн зууны 70-аад оны үед бий болсон Терумато Озава /Terumoto Ozawa/ санаачилсан. файкл чортерийн /Micheal Porter/ санаад тулгуурлан гадаадын шууд хөрөнгө оруулалт болон эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварын хамаарлыг судласан. Гадаадын хөрөнгө оруулалтын гадагш болон эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварын хамаарлыг судалсан. Гадны хөрөнгө оруулалтын гадагш болон дотогш урсгалын хэлбэлзлийг судлахдаа хөгжлийн үндсэн 3 фазыг тодорхойлсон.

1-р фаз. Улс буурай хөгжилтэй байх ба өөрийн ажиллах хүчний хямд байдал гэх мэт давуу талыг гадаадын компаниудад ашиглуулахыг зорино. Бараг л хөрөнгө оруулалтын гадагш урсгал байхгүй.

2-р фаз. Шинэ хөрөнгө оруулалт нь дотоод зах зээлийн өсөлт болон амьдралын түвшний сайжралтыг бий болгоно. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын гадагш урсгал нь нь хөдөлмөрийн зардлын өсөлтөөр идэвхижнэ.

3-р фаз. ъухайн орны өрсөлдөх чадвар нь шинэчлэлд тулгуурлана. Хөрөнгө оруулалтын гадагш болон дотогш урсгал нь зах зээлийн болон технологийн хүчин зүйлээр идэвхижнэ.

Жон Даннингийн (John Dunning) 5 үе шатны онол

1-р шат. Доогуур орлоготой хөрөнгө оруулалт, гэхдээ гадаадын компаниуд тухайн орны давуу талыг нээж эхлэнэ. Гадааын гадагш урсгал байхгүй, дотоодын үйлдвэрлэгчид өөрийн гэсэн онцгой давуу тал байхгүй.

2-р шат. Тухайн улсын хямд ажиллах хүчний давуу талыг ашигласнаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын орлого өснө. ылс руу илүү их гадаадын компанийг оруулснаар амьдралын түвшин сайжирна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын гадагш урсгал доогуур хэвээр байна.

3-р шат. Орлого өндөртэй хөрөнгө оруулалт хэвээр байх ч шалтгаан нь хөдөлмөрийн хөлсний өсөлтөөс шалтгаалан өөрчлөгдөнө. Дотоодын үйлдвэрлэгчид давуу талаа хөгжүүлснээр хүчтэй болж гадагш гарах гадаадын шууд хөрөнгө оруулалт ихсэнэ.

4-р шат. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын гадагш урсгал нь хямд ажиллах хүч гэх мэт давуу талыг хилийн чанад руу хайхаар гарна.

5-р шат. эөрөнгө оруулалтын шийдвэр нь Үндэстэн дамнасан корпорацийн стратегид тулгуурлана. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын гадагш урсгал болон дотогш урсгал нь тэнцвэржинэ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын микро түвшний онол

Монополист давуу талын онол /Monopolist Strenght Theory/: Энэ онолыг анх Харвардын эдийн засагч Стефен Хаймерийн /Stephen Hymer/ 1960 онд хамгаалсан диссертациас эхлэн хөгжсөн гэж үздэг. Түүний онолоор гадаадын хөрөнгө оруулагч нь монополист гэхээсээ илүү бүтээгдэхүүний зах зээл дувополист бөгөөд тухайн зах зээлийн пүүсүүд эзэмшдэггүй давуу технологи, маркетинг, менежмент, санхүүгийн давуу мэдлэг туршлагадаа үндэслэн гадаадын зах зээлд шууд хөрөнгө оруулалт хийдэг байна. Энэ нь компанийн нууцаа алдахгүйн тулд хамгаалалтын стратегийн үүднээс хөрөнгө оруулалтын шууд хэлбэрийг сонгоход хүрдэг.

Пүүс онцгой давуу талтай байх Хаймерын (Hymer 1960) онол. (Аж үйлдвэрийн байгууламжийн онол)– Үндэстэн дамнасан корпорацид анхаарлаа хандуулж олон улсын валютын арилжаа бус олон улсын үйлдвэрлэлд чиглэсэн. Дотооддоо үйлдвэрлэл явуулахаас гадаадад үйлдвэрлэлээ явуулах, сул талыг давж гарах дараах давуу талтай

байна. Тухайлбал: түүхий эд материалын олдоц, эдийн засгийн хэмжээ, капитал, менежмент, технологи, маркетинг, зах зээл дэх мөчидхөн арилжаагаа гадны пүүсийн арилжаагаар сольсноос гарах арилжааны зардлын бууралт түүнчлэн алдартай брэнд, патентаар хамгаалагдсан технологи, менежментийн ур чадвар гэх мэт биет бус хөрөнгө болон бусад пүүсийн онцгой хүчин зүйлтэй байж байж гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хийнэ гэж үзжээ. ыг биет бус хөрөнгийг борлуулах болон түрээслүүлэхэд хэцүү учраас гадаадын шууд хөрөнгө орлуулалт өснө. Жишээ нь, тока кола гадны пүүст колаг үйлдвэрлүүлэх лиценз өгөхийн оронд дэлхий даяар савлах тоног төхөөрөмжөө тархаан суурилуулсан. Энэ нь колаг үйлдвэрлэх нууц жороо хамгаалах үүднээс хийгдсэн хөрөнгө оруулалт юм. 1960-аад оны үед Энэтхэг дэх үйлдвэрээ тухайн ЗГ коланы жорыг илрүүлэхийн тулд хийсэн шахалт дарамтны улмаас хаажээ.

Уг онолын хязгаарлалт нь пүүс яагаад өөрийн давуу талаа эх орондоо ашигладаггүй, экспортлодоггүй гадаадын шууд хөрөнгө оруулатыг сонгодог. Мөн А улсаас илүү Б улсыг яагаад сонгодог гэдгийг тайлбарладаггүй.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба олигополист зах зээл

Никербокерийн онол /Knickerbockers Theory/: Тус онолын гол санаа нь олгиполист үйлдвэрлэлийн тэргүүлэгч пүүс шинэ зах зээлд нэвтрэн ороход нь бусад нь дагадаг байна. Тиймээс дагагч буюу хоорондоо өрсөлдөж буй компаниуд /нэг салбар үйл ажиллагаа явуулдаг компаниуд/ нь анхдагч хөрөнгө оруулагч үйлдвэрлэлээ явуулж эхэлмэгц зах зээлд байр сууриа хадгалах үүднээс хөрнгө оруулалт хийж эхэлдэг.

Олигополь дах зээлд пүүсүүд зах зээлд тэргүүлэгчийнхээ хөдлөлийг дагах ба харилцан дайралт буюу тоглоомын онол. хикербокер олигополь орчинд тэргүүлэгчийн хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бусад пүүсүүд өөрийн зах зээлийн эзлэх хувиа хадгалахын тулд даган ижил үйлдэл хийнэ гэж үзсэн. фөн олигополист хариу үйлдэл төвлөрлийн түвшнээс хамааран өсөх ба бүтээгдэхүүний төрөлжилтөөс хамааран буурдаг гэсэн байна.

Олон төрлийн гадаадын хөрөнгө оруулалтын онол (electric OLI paradigm)

Төгс бус зах зээлийн дагуу пүүс өөрийн монополь давуу талаа ашиглах сонирхолтой байдаг хэд хэдэн шалтгаан бий.

- Бүтээгдэхүүний чанарыг хангах
- Түүхий эд материалын хангамжийг бүрдүүлэх
- Фэдлэгийн зах зээл

Баклей болон тассон нар пүүс өөрийн зах зээл-олон улсжуулалтыг бий болгосноор зах зээлийн төгс бус байдлыг давна гэж үзсэн. олон улсжилтын давуу тал нь цаг хугацааны хоцролтоос, хэлэлцээр болон худалдан авагчийн тодорхой бус байдлаас сэргийлэх юм. Олон улсжих онол пүүсүүд яагаад лиценз, экспорт, импортыг сонгохын оронд гадаадын хөрөнгө оруулалтыг сонгодог гэдгийг тайлбарладаг. Зах зээлийн худалдан авалт болон борлуулалтаас шалтгаалсан цаг хугацааны хоцролт болон арилжааны зардлаас болж пүүс зарим нэгэн зах зээлийн үүргээ гадаад процессоор сольдог, энэ нь intra-пүүсийн солилцоо юм. ъүүнчлэн олон улсжих процесс нь тодорхой бус байдлыг багасгадаг бөгөөд хил даван олон улсжснаар пүүс олон үндэстний болдог.

Олон улсжуулалтын онол нь яагаад гадаадын шууд хөрөнгө оруулалт бий болдгийг тайлбарлахад удаан хэрэглэгдсэн.

Олон улсын үйлдвэрийн тухай Даннингийн Эклетик онол /Dunning Eclectic Theory/: Даннингийн онолоор пүүс шинэ хөрөнгө оруулалт хийхэд доорхи гурван төрлийн давуу талыг эзэмшсэн байх ёстой. Үүнд:

1. Пүүс нь бусдад байдаггүй материаллаг бус активыг олж чадах эсвэл эзэмшиж байх
2. Уг давуу талаа гадаадад хөрөнгө оруулалтын хэлбэрээр хэрэгжүүлэн ашиглах
3. Пүүс өөрийн эзэмшилийн үйлдвэрийг далайн чандад байгуулсанаар ашгаа дээшлүүлэх болно.

OLI (Ownership, Location, Internalization) онол

OLI онолоор доорх 3 нөхцөл хангагдсан үед компани нь гадаадын шууд хөрөнгө оруулалт хийдэг. Үүнд:

- Компани нь гадаадын байрласнаас үүсэх дутагдалай талыг давж чадахуйц ур чадвар, хөрөнгө (assets)-ийг эзэмшиж байх, энэххүү ур чадвар, хөрөнгө нь оюун ухааны өмч (технологи болон брэнд нэрийг оруулаад), зохион байгуулалтын болон удирдлагын ур чадвар, зах зээлийн сүлжээг багтаана.
- Тухайн бүтээгдэхүүнийг нэг улсад үйлдвэрлэн экспортлосноос үйлдвэрлэлийг улсуудад хуваан явуулах ямар нэгэн байршлын давуу (Location advantage) тал байх ёстой.
- Тухайн пүүсийн гадаадад хөрөнгө оруулснаас олох ашиг нь ур чадвар, хөрөнгөө гадаадын компанид лицензи олгох ашгаас их байх ёстой ба хөрөнгө оруулснаас олох давуу тал нь том өргөн, газар зүйн хувьд тархсан компанийг янз бүрийн хуулийн болон соёлын өв уламжлалтай улсуудад удирдахад гарах зардлыг нөхөхөд хангалттай байх ёстой.

Энэхүү загвар нь доорх 3 зүйлийн үйлчлэлийн улмаас OLI онол гэсэн нэрээр тархжээ. Энэ нь эзэмшил (Ownership), байршил (Location), зах зээлд өөрөө нэвтрэн орох (Internalization) юм.

Эзэмшил (Ownership)

Орон нутгийн орчинтой илүү танил орон нутгийн пүүсүүдтэй өрсөлдөхийн тулд гадаадын шууд хөрөнгө оруулагч нь өөрийн үйл ажиллагааг олон зах зээлд ашиглаж болохуйц, үүний зэрэгцээ нэмэгдэл зардал шаардахгүй ур чадвар, хөрөнгөд суурилуулдаг. Үндэстэн дамжсан компаниуд нь өөрсдийн технологийн давуу талыг тэдний хамгийн хүчтэй давуу тал гэж үздэг байна. Үүний дараагаар зах зээлийн болон удирдлагын ур чадвар ордог байна.

Байршил (Location)

Үйл ажиллагааны байршлыг тодорхойлдог зүйл нь мэдээж хэрэг хөрөнгө оруулалтын шинж чанар болон зорилготой холбоотой байршлын давуу тал юм. Зарим үйлчилгээний салбарт хил хоорондын үйл ажиллагааны зардал их өндөр байдаг бөгөөд үүний улмаас хэрэглэгч улсад арилжааны төлөөлөл байх шаардлага гардаг. Зочид буудлын үйлчилгээ үүний нэг жишээ юм. Гадаадын банкууд ерөнхий дотоодын банкуудтай өрсөлдөхийн тулд өөрийн сүлжээ салбарыг байгуулах шаардлагатай гэж үздэг.

Үйлдвэрлэлийн зардлыг бууруулахын тулд үндэстэн дамжсан корпораци нь үйлдвэрлэлийн процессын янз бүрийн шат дамжлагыг өөр өөр улсуудад байршуулдаг. Энэ төрлийн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэлийн процессын салбарлалт босоо

байрлалтай учир (vertical) гэж нэрлэдэг. Үүний хажуугаар ижил төрлийн болон яг адил бүтээгдэхүүний үйл ажиллагааг өөр өөр улсуудад байршуулсан байдаг. Үүнтэй холбоотой гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хэвтээ (horizontal) хөрөнгө оруулалт гэдэг. Ерөнхийдөө, өргөжилтийн үр өгөөжтэй хөрөнгө оруулагч нь үйлдвэрлэлийн хэмжээг хангалттай хэмжээнд байлгах том зах зээл дээр байрладаг. Гэсэн хэдий ч жижиг орнууд хангалттай дэд бүтцийг байгуулж чадвал экспортын чиглэлийн хөрөнгө оруулалтыг татах боломжтой.

Хөрөнгө оруулалтын байршлыг тодорхойлоход зайлшгүй бодолцож үзэх нэг асуудал бол эрсдлийн төрөлжүүлэлт (risk diversification) юм. Үндэстэн дамжсан корпорациуд санхүүгийн хөрөнгө оруулагч нарын адил хүлээгдэж буй ашиг эрсдлийн үнэлэмжээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах нь элбэг тохиолддог.

Зах зээлд өөрөө нэвтрэн орох (Internalization)

Гурав дахь зүйл нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын зах зээлд өөрөө нэвтрэн орохтой холбоотой асуудлыг авч үзнэ. Энэ нь орон нутгийн аж ахуй эрхлэгчтэй гэрээ хэлцэл хийх замаар бус харин хөрөнгө оруулагч өөрөө ур чадвар хөрөнгөө ашиглан бусдын зах зээлд нэвтрэн ажиллах гэсэн үг юм.

Орон нутгийн аж ахуй эрхлэгчтэй гэрээ хэлцэл хийх нь бүрэн дүүрэн ойлголтгүй хуулийн болон институтын бүтэц, бизнесийн өөр өөр уламжлал, шинэ хэл, соёл гэх мэт саадтай зах зээлд нэвтрэх зардлыг багасгаж чадна. Гэсэн ч гэрээ хэлцэл хийх нь хэд хэдэн дутагдалтай талтай. Үүнд:

- Шинэ технологи эзэмшигч нь лиценз эзэмшигчид бүх төрлийн нарийн мэдээллийг өгөхөөс зайлсхийж болох юм. Ер нь шинэ технологийг компаниуд өөрсдөө зах зээлд орж ирж ашигладаг, харин хуучин технологийг гэрээ хэлцэл хийх замаар шилжүүлэн ашигладаг явдал ажиглагдсан байна.
- Ур чадвар, хөрөнгийг хөрөнгө оруулагч компаниас авахад түвэгтэй байж болох юм.
- Лиценз эзэмшигчийн үйл ажиллагаа хөрөнгө оруулагч компанийн нэр хүндэд сөрөг нөлөө учруулж болзошгүй гэсэн болгоомжлол байдаг.
- Шүүхийн тогтолцоо нь лиценз эзэмшигч гэрээ, хэлцлийн нөхцлийг зөрчсөн үед албадан хууль мөрдүүлэх чадвар нь сул гэсэн ойлголт байж болно.

Дээрх бэрхшээлүүдийн улмаас хөрөнгө оруулагч компани нь өөрөө бусдын зах зээлд нэвтрэн үйл ажиллагаа явуулахыг эрмэлздэг.

Олон төрлийн үзэл санааг нэгтгэхийг оролдсон, макро эдийн засгийн онол болон худалдаа, түүнчлэн микро эдийн засгийн онол болон пүүсийн зан төлөвийн онол гэх мэтийг оролцуулсан.

Интернационалчлах онол /Internationalize Theory/: Уг онолоор илүү мэдлэг туршлагатай компани нь хөрөнгө оруулалтаас хамгийн их ашиг хүртэх үүднээс давуу нууц мэдлэгээ /чадвараа/ лицензээр олгох, нээлттэй зах зээл дээр худалдаалахаас илүү гадаадад шинэ хөрөнгө оруулалт хийх сонирхол үүсдэг байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр

Аливаа нэг улсын хөрөнгө оруулагч өөр улсад бизнесээ өргөжүүлэх замаар аж ахуйн нэгжийн хувьцааг эзэмших бөгөөд нийт хувьцааны эзэмших хэмжээ нь хөрөнгө оруулагчид аж ахуйн нэгжийн удирдлагын хяналтыг өгч байх үед гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдлээ гэж ойлгодог. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг санхүү (portfolio)-ийн бусад

хөрөнгө оруулалтаас ялгаж байгаа гол зүйл бол удирдлагын цар хүрээ юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө оруулалтын аль аль нь тухайн улсад ашигтай байдаг.

Гадаадын хөрөнгө оруулалтыг

1. Багцын хөрөнгө оруулалт
2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж хуваадаг байна.

Багцын хөрөнгө оруулалт гэдэг нь хөрөнгө оруулагч тал тухайн аж ахуйн нэгжийн дүрмийн сангийн 10-аас доош хувийг эзэмшиж байгаа хэлбэрийг хэлнэ. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагчид актив хөрөнгийг үнэт цаас хэлбэрээр бонд, хувьцааг худалдан авч ногдол ашгийн хэмжээнд илүүтэй анхаардаг ба үйлдвэрийг шууд удирдах боломжийг олгодоггүй.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэдэг нь хамтарсан үйлдвэр, дагнасан болон бусад хөрөнгө оруулалтын хэлбэрүүд хамаарах бөгөөд энэ тохиолдолд хөрөнгө оруулагч нь тухайн компанийн дүрмийн сангийн 10-аас дээш хувийг эзэмшинэ гэж үздэг ба компанийн менежментэд хяналт хийх боломжийг хөрөнгө оруулагчид олгодог.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ихэвчлэн үндэстэн дамнасан корпораци (multinational enterprises)-ууд байдаг. Үнэн хэрэгтээ гадаад дахь хөрөнгө оруулалт нь компаниудыг үндэстэн дамжсан болоход хүргэдэг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь 3 хэсгээс бүрдэнэ:

- Хувьцаа эзэмших. Гадаадын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн хувьцааг худалдаж авах,
- Ашгаас дахин хөрөнгө оруулах (reinvested earnings) гадаадын хөрөнгө оруулагчид ногдох ашгийг хуваарьлалгүйгээр, эсхүл гадаадын хөрөнгө оруулагч руу шилжүүлэлгүй эргүүлж оруулсан ашиг,
- Компани доторх зээл эсхүл өрийн шилжүүлэг (intra company debt transactions) шууд хөрөнгө оруулагч болон харъяа компанийн хооронд хийгдэх урт болон богино хугацааны зээл болон зээллэг.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд урсгал (Flow) болон тухайн хугацааны эцсийн байдлаарх (Stock) гэсэн ойлголт байдаг. Урсгал гэдэгт гадаадын шууд хөрөнгө оруулагчаас шууд хүлээн авсан хөрөнгийн хэмжээг ойлгодог бол тухайн хугацааны эцсийн байдлаарх гэдэгт толгой компанид хамаатай хөрөнгө болон нөөц хөрөнгийн хувь хэмжээний үнэ цэнэ (Value), дээр нь толгой компанитай хийх цэвэр өрийн хэмжээг нэмсэнтэй тэнцэнэ.

Сүүлийн жилүүдэд зарим улсын засгийн газар нийтийн зориулалттай төслийг хувийн секторын хөрөнгөөр санхүүжүүлэх болсон байна. Энэ нь төсвийн хөрөнгө хомс, засгийн газрын агентлагуудын төсөлд шууд оролцох боломжгүй зэрэг шалтгаантай холбоотой. Нийтийн зориулалттай төслийг хувийн хөрөнгөөр санхүүжүүлэх нэг арга бол барих, ажиллах, шилжүүлэх (Build, Operate, Transfer) загвар юм. Энэ загварын гол онцлог бол хувийн сектор төслийг боловсруулж, санхүүжүүлж, барилга байгууламжийг бий болгож, улмаар уг нэгжийн хэвийн ажиллуулж, хэсэг хөнгөлөлттэй хугацааны дараа эзэмшлээ засгийн газарт шилжүүлнэ. Уг загвар нь хувийн секторын хөрөнгийг ашиглан дэд бүтцийн төслийг санхүүжүүлэх нэг арга юм. Эдгээр төслүүд нь нийтийн хэрэгцээг хангах, нийтэд үйлчлэхэд, мөн хувийн секторын эдийн засгийн идэвхийг дэмжихэд чиглэсэн байдаг. Жишээ нь зам, гүүр, цэвэр усны болон бохирын шугам, онгоцны буудал болон барилга зэргийг дурьдаж болно. Хөнгөлөлтийн хугацаа нь ихэвчлэн 25-40 жил байдаг. Өөр төслийг

хэрэгжүүлэх олон загвар байдаг бөгөөд эдгээр нь хоорондоо тухайн төслийг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдлийг хуваан болон улсын секторт хэрхэн хуваасаар ялгагдана.

Гадаадын хөрөнгө оруулалт эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг тал

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь эерэг сөрөг гэх мэт янз бүрийн нөлөөг үзүүлдэг бөгөөд эерэг нөлөөлөл болон түүний ач холбогдлыг талаар авч үзье. Үүнд:

1. Хөрөнгийн тогтмол аюулгүй эх үүсвэрийг бий болгодог.
2. Тухайн улсад дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлдэг
3. Бизнесийн хөгжил бий болгодог
4. Ажил эрхлэлт, бүтээмж, ур чадварыг нэмэгдүүлдэг
5. Эдийн засгийн өсөлтийг бий болгодог.

Сөрөг тал

1. Капиталыг өөрийн орны дотоодын хөрөнгө оруулалтанд ашиглах, ногдол ашиг, хүү зэрэг хэлбэрээр ашгийг шилжүүлэн авах нь тухайн орны төлбөрийн тэнцлийг муутгана.
2. Онгон байгалийн баялгыг зүй бусаар ашиглаж, үрэн таран хийх.
3. Улс оронд “Бохир” үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдийг ховдоглон ашиглагчдыг ирүүлснээр байгаль орчны байдал муудна.
4. Өрсөлдөөнийг хязгаарлан нутаг орны үйлдвэрлэгчид, нийлүүлэгчдэд дарамт үзүүлнэ.
5. Нутаг орны нөхцөл, онцлогыг гадаадын хөрөнгө оруулагчид үгүйсгэн үндэсний эдийн засгийн бүтцийг гуйвуулна.
6. Гадаадын үйлдвэр дэх цалин хөлсний илүү өндөр түвшин нь нийгмийн ялгаат байдлыг бий болгоно.
7. Төрөл бүрийн хэлбэрээр гадаадын технологи оруулах нь өөрийн оронд эрдэм шинжилгээ сорил туршилтын ажил явуулах түлхэцийг хязгаарлан түүний дүнд технологийн хамааралт байдлыг хүчтэй болгоход хүргэнэ.
8. Үндэсний зан заншил үл ойшоох, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, амжиргааны хэв маягт үндэсний бус хэлбэрийг суулгахтай холбоотойгоор нийгэм, соёлын нөхцөлд сөрөг нөлөө үзүүлнэ.
9. Засгийн газрын удирдамж, хяналтыг үл ойшоон, үндэсний бодлого, хөгжлийн төлөвлөгөөний биелэлтэнд хөндлөнгөөс саад учруулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ
МОНГОЛ УЛСЫН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эмпирик судалгаагаар Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн цагаас өнөөг хүртэлх эдийн засгийн өсөлт, ДНБ-нд эзлэх гадаадын хөрөнгө оруулалтын тойм сонгон авч судаллаа. Ингэхдээ эдийн засгийн өсөлт, ДНБ-ийн өсөлт бий болсон жилүүдэд төрөөс баримталсан бодлого, эрх зүйн орчин, гадаад секторын нөхцөл байдлуудыг тус тус судалсан болно. Нөгөө талаар эдийн засгийн бүтцийн хувьд гадаадын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн аль салбарт илүү нөлөөлж байгааг судлахыг зорьсон болно.

Монгол улсын эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтын түүхэн тойм.

Монгол улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч эхэлсэн. Энэ үеэс гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаадын хөрөнгө оруулагчид Монгол улсыг илүүтэй сонирхох болсон.

Эрх зүйн орчин

1993 оны 05 дугаар сарын 10-нд УИХ-аас “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хууль батлагдсанаар гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно. Үүнээс хойш 1998, 2002 онуудад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бөгөөд эдгээр нь хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох чиглэсэн юм. 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан гаргаснаар хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг цогцоор шийдсэн боловч бодит байдал дээр хуулийн хэрэгжилт муу байна.

1993 оны хуулиар ***гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулагч, Монголын хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын гэрээ*** гэх мэт нэр томъёонуудыг тодорхойлсноор эрх зүйн орчныг бүрдүүлжээ.

Хөрөнгө оруулалтын хуулийн зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах, гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад чиглэгдэж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж нийт компанийн 33 хүртэлх хувийг эзэмшихээр тусгажээ. Ингэхдээ банк, санхүү, хэвлэл мэдээлэл, уул уурхайн салбарт хязгаарлалт тогтоосон байна.

Харин 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан гаргаснаар дараах онцлог зохицуулалтыг тусгаж чадсан байна.

Эрх зүйн хамгаалалт

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид ижил тэгш нөхцөл олгох
- Зөвшөөрөл авахгүй ба улсын бүртгэлд бүртгүүлснээр үйл ажиллагаагаа эхлүүлэх
- Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулан, татварын орчныг тогтвортой байлгах
- Татвар төлсний дараа хөрөнгө, орлогоо гадаадад саадгүй гуйвуулах
- Оюуны өмчийг хамгаалах
- Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар хураан авахыг хориглох
- Энэ хуульд УИХ-ын нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар өөрчлөлт оруулах

Хөрөнгө оруулалтыг дэмжих

- Татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ.
- Татварын дэмжлэг:

Албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, элэгдлийн зардлыг түргэвчилсэн аргаар тооцох, ажилтны сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасч тооцох;

Барилгын материал, газрын тос, ХАА-н боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр, нано, био, инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барихад импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татваырг “о” хүртэлх хувиар ногдуулж болох.

Татварын бус дэмжлэг

- Газрыг 60 хүртэл жилээр эзэмшүүлэх, уг хугацааг 40 хүртэл жилээр сунгах
- Дэд бүтэц, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, чөлөөт бүс,үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулахад бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх, хөнгөвчилсөн горимоор үйлчлэх
- Экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжүүлтэд батлан даалт гаргах
- Хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах
- Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар төсөл хэрэгжүүлэх этгээдэд хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах;
- Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтворжуулах.

Хөрөнгө оруулалтын хуульд дараах нэр томьёог шинэчлэн тодорхойллоо.

“Хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан, бие болон бие бус хөрөнгийг”

“Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг;”

“Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд” гэж нийт гаргасан хувьцааных нь 50, түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийг;” гэж нэр томъёог шинэчлэн тогтоожээ.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улс зах зээлийн харилцаанд нэвтэрснээс хойш гадаадын хөрөнгө оруулалт 1990 онд 0.96 сая ам.доллар байсан бол 1996 онд 53.63 сая ам.доллар, 2001 онд 123.17 сая ам.доллар болсон бөгөөд, 2006 онд 206.6 сая ам.доллар болж 1990 онтой харьцуулахад бараг 200 дахин өссөн байна. Гэхдээ нийт хөрөнгө оруулалтын 76.3%/ 1254.14 сая ам.долларыг 2001 оноос хойш буюу сүүлийн 6 жилд оруулсан байна.

2005 – 2010 оныг хүртэл 3,73 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан бөгөөд 2010 оноос Монгол улсыг гадны хөрөнгө оруулагчид ихээр сонирхох болж гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж нэмэгдэн 2011 онд л гэхэд 4,99 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн 5 жилийн нийт гадаадын хөрөнгө оруулалтыг давав. (Хүснэгт 1)




2004 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 123 сая ам. доллар буюу ДНБ-ий 5.8 хувьтай тэцүү байсан бол 2008 онд энэ үзүүлэлт 683 сая ам. доллар буюу ДНБ-ий 13 хувьтай тэнцүү болтол өссөн. 2009 онд дэлхийн санхүүгийн хямралын үр дүнд дэлхийн зах зээл дээрх алт, зэсний үнэ огцом буурахад Монголын эдийн засгийн бодит өсөлт 1.3 хувиар буурсан байна.

2011 онд Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ огцом өсч тэр хэрээр уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр оргил үедээ хүрсэн юм. Гэсэн хэдий ч 2012 оноос Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурснаар 2014 онд -82,31%-ийн хасах гүйцэтгэлтэй гарчээ.

2017 оноос Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь дотоод хүчин зүйл гэхээс илүүтэй БНХАУ-ын импортын бодлогод өөрчлөлт орж, эрэлт нэмэгдсэнтэй холбон

тайлбарлаж болно. Энэ нь манай улс шиг уул, уурхайн салбарын экспортын хувьд таатай орчин бий болсны улмаас эргэн Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэх сонирхол нэмэгдсэн. OLI загварын хувьд бидний том давуу тал нь урдаа БНХАУ-тай, хойд хилээрээ ОХУ-тай хиллэдэг газар зүйн байршил юм.



2024 оны 3 дугаар улиралд Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 830 сая ам.доллар, харин хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 289 сая ам.доллар байснаар цэвэр дүнгээр 541 сая ам.долларын орох урсгалтай байв.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 47 сая ам.долларoop буурсан байна. Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 2. ГШХО-ын орох урсгал, улсаар, сая ам.доллар

Үзүүлэлт	2023.III	2024.III	2024.III/23.III Өөрчлөлт	
Нидерланд	293	386	93	▲
Сингапур	112	178	66	▲
Их Британи	208	67	-141	▼
БНХАУ	55	47	-8	▼
Япон	36	33	-3	▼
АНУ	35	29	-7	▼
Люксембург	15	20	5	▲
Хонг-Конг	4	15	11	▲
БНСУ	44	11	-33	▼
Белги	17	9	-7	▼
Кайманы арлууд	0	6	6	▲
Канад	28	6	-22	▼
ОХУ	15	3	-12	▼
Франц	3	3	0	▼
Герман	1	2	2	▲
Бусад	12	14	2	▲
Нийт	**876**	**830**	**-47**	▼

- Нидерланд улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 93 сая ам.долларoop өсөж 386 сая ам.доллар,
- Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 66 сая ам.долларoop өсөж 178 сая ам. долларт хүрсэн бол,
- Их Британи улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 141 сая ам.долларoop буурч 67 сая ам.доллар,
- Бүгд Найрамдах Солонгос улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 33 сая ам.долларoop буурч 11 сая ам.доллар,
- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 22 сая ам.долларoop буурч 6 сая ам.долларын орох урсгалтай байна.

1990 оноос 2015 он хүртэл нийт Гадаадын шууд хөрөнгө оруулалтын компанийг салбараар авч үзвэл Худалдаа, нийтийн хоолны салбарт хамгийн их хөрөнгө оруулалт буюу нийт ГШХО-ын компанийн 69,4%-ийг эзэлж байсан бол 2024 оны байдлаар Уул уур, олборлолтын салбар нийт шууд хөрөнгө оруулалтын 82.6%-ийг эзэлж байна.



Худалдаа, нийтийн хоолны салбарт хамгийн олон Гадаадын шууд хөрөнгө оруулалттай компанийн 69,4%-ийг эзэлдэг худалдаа, нийтийн хоолны компаниуд нийт ГШХО-ын 17.8%-ийг эзэлж бусад салбаруудаас банк санхүүгийн салбар 1.4%, тээврийн салбар 1.2 %-ийг эзэлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2023
Нийт	3,533.31
Барилга	19.2
Боловсрол	0.84
Боловсруулах үйлдвэрлэл	4.07
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	246.59
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.44
Мэдээлэл, холбоо	28.26
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	217.43
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.18
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	133.52
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	40.18
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	50.55
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.07
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0
Уул уурхай, олборлолт	2,759.43
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.93
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4.98
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.27
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	18.92
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0.67
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.77

2005 оноос Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо огцом өсч 2007 онд 1609, 2008 онд 1551 компаниуд жилд байгуулагдаж байсан бол энэ тоо 2009 оноос 60,5%-иар буурч 2014 онд 335 аж ахуйн нэгж байгуулагдсан бол 2015 оноос буурч, 2017 оноос Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагын тоо өсөж 2126 аж ахуйн нэгж байна.

Өмчийн хэлбэр	2018	2019	2020	2021	Дүнд эзлэх хувь			
					2018	2019	2020	2021
Бүгд	71 717	75 522	76 329	81 533	100.0	100.0	100.0	100.0
Төрийн болон орон нутгийн	4 926	5 030	5 105	5 277	6.9	6.7	6.7	6.5
Монгол Улсын иргэний хувийн	63 798	67 445	68 411	73 576	89.0	89.3	89.6	90.2
Хувийн гадаадтай хамтарсан	756	645	586	554	1.1	0.9	0.8	0.7
Гадаад улсын	2 237	2 402	2 227	2 126	3.1	3.2	2.9	2.6

Гадаадын хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалт 2024 оны 3 дугаар улиралд -42,854 сая ам.долларын богино позицтой байна

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 8,699 сая ам.доллар байна. Үүний 54%- ийг гадаад валютын албан нөөц, 29%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, 6%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяат аж ахуйн нэгж, байгууллагуудад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 51,553 сая ам.долларт хүрэв. Үүний 63%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 32%-ийг бусад хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Позиц, сая ам.доллар

Үзүүлэлт	2023.III	2024.III	Өөрчлөлт	
			дүн	*хувь*
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	**-40,815**	**-42,854**	**-2,039**	**5%**
I. Гадаад актив	**8,185**	**8,699**	**514**	**6%**
Шууд хөрөнгө оруулалт	1,018	1,019	1	0%
Багцын хөрөнгө оруулалт	514	513	-1	0%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	1	0	-1	-94%
Бусад хөрөнгө оруулалт	2,528	2,505	-23	-1%
Нөөц актив	4,124	4,663	538	13%
II. Гадаад пассив	**49,000**	**51,553**	**2,553**	**5%**
Шууд хөрөнгө оруулалт	29,869	32,355	2,485	8%
Багцын хөрөнгө оруулалт	3,018	2,752	-266	-9%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	8	8	17.6x
Бусад хөрөнгө оруулалт	16,113	16,439	327	2%

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 2,039 сая ам.долларoop өссөн байна.


Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулж байгаа бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 12% буюу 2626 сая ам.долларaap нэмэгдсэн. Үүнд: ШХО-ийн богино позиц 477 сая, багцын ХО 69 сая, бусад ХО-ын эх үүсвэр 1467 сая ам.долларaap тус тус өсч, ГВУН 619 сая ам.долларaap буурсан нь нөлөөлжээ.

2024 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт гадаад актив 6%-иар буюу 514 сая ам.долларaap, гадаад пассив 5% буюу 2,553 сая амдолларaap тус тус өссөн байна.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 51%-ийг буюу 16,655 сая ам.долларыг гадаадын хөрөнгө оруулалттай компанийн толгой компаниасаа авсан зээлийн эх үүсвэр, 49% буюу 15,699 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сангийн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.


Зураг 11. Гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллар



Багцын хөрөнгө оруулалт

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн болон Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалтын харилцан хамаарал

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ



Дээрх хүснэгтээс харвал Гадаадын шууд хөрөнгө оруулалт, ДНБ-ний өсөлтөнд эерэг хамааралтай байна. Гэвч Гадаадын хөрөнгө оруулалтын савалгаа нь Дотоодын Нийт Бүтээгдэхүүний өсөлтөнд шууд нөлөөлж байгааг хүснэгтээс харж болно. Тухайлбал, 2009 оноос Гадаадын хөрөнгө оруулалт огцом өсөхөд ДНБ дагаж өссөн дүн харагдаж буй бол, 2011 оноос Гадаадын хөрөнгө оруулалт огцом буурахад ДНБ шууд унасан дүр зураг ажиглагдаж байна.

2024 оны байдлаар ДНБ-ий өсөлтөд ГШХО 51,553 сая ам.долларт хүрсэн нь эерэг хамааралтай болохыг харуулж банйа.

Монгол улсын эдийн засаг гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) гэж ерөнхийдөө нэг улсаас нөгөө рүү хөрөнгө, технологи, ноу-хау урсахыг хэлнэ. Олон улсын хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтаас шууд өгөөж хүртдэг бол эзэн орон ямар ашиг хүртэх нь тодорхойгүй байдаг. Өнгөц харахад, хөрөнгө, боловсронгуй технологи, сайжруулсан удирдахуйн чадвар зэрэг ашиг тусыг тухайн улсад хүртээнэ. Гэвч эдгээр ашиг тус нь автоматаар эзэн улсын үр ашиг18 болж хувирдаггүй. Энэхүү процесс нь эзэн улс хангалттай шингээх чадвартай байх нөхцөлийг шаарддаг. Хөгжиж буй олон улсууд ГШХО-ыг урин далладаг боловч ГШХО-аас ашиг шингээж авахын тулд анхан шатны нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой гэдгийг ойлгодоггүй. Nunnemkamp (2004) аливаа улс ГШХО-ыг ашиглахаас урьтаж эдийн засгийн хөгжлөө минимум түвшинд хүргэсэн байх шаардлагатай, эс бөгөөс ГШХО-аас их зүйл хүлээгээд нэмэргүй гэжээ.[2]

1990-ээд оноос хойш дэлхий даяар ГШХО-ын хэмжээ огцом өссөн. ГШХО-ын хэмжээ 1990 оны үеэс даруй 3 дахин нэмэгдсэн бол 2000 оны байдлаар, хувийн хөрөнгийн урсгалын 50%-иас илүүг хөгжиж буй улсуудад орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна. Эндээс ГШХО нь дэлхийн бөмбөрцгийг маш их хамарсан, хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтийг дэмжих хүчтэй хөшүүрэг болж ач холбогдол нь улам бүр нэмэгдэж, даяаршлын нэгэн илэрхийлэл болсон нь харагдана.[3]

Гэвч хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтөд ГШХО-ын үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байна. Үүний шалтгааныг өмнөх үеийн судалгаануудад тухайн улсын шингээх чадвараас хамаардаг гэж үзсэн. Энэхүү тайлбарын үндэс нь, хөгжиж буй улс нь дэвшилт технологид хандсанаар өөрийнхөө хөдөлмөрийн нийт бүтээмж19 (ХНБ)-ийг нэмэгдүүлнэ гэсэн ГШХО-ын үзэл санаанд (номлолд) оршино.[3]

Ихэнх судалгааны ажлуудад гадаадын хөрөнгө оруулалт ашигтай байх эсэх нь тухайн орны хөрөнгө оруулалтын шингээх чадвараас ихээхэн хамаардаг болохыг тогтоосон байна. Хувь хүмүүс шингээх чадвараа дээшлүүлж чадвал энэ нь байгууллагын шингээх чадварыг өсгөнө, байгууллагууд шингээх чадвараа дээшлүүлж чадвал улс орны шингээх чадвар өснө гэсэн хөрөнгө оруулалтын шингээх чадварын үндсэн санаад тулгуурлан Сигне Крогстрап, Линда Матаар нар:

1. Технологийн ялгаа

2. Ажиллах хүчний боловсролын түвшин

3. Санхүүгийн хөгжил

4. Институцийн хөгжил гэсэн хүчин зүйлүүдийг ашиглан тухайн нэг улс орны хөрөнгө оруулалтын шингээх чадварыг тодорхойлох боломжтой гэж үзсэн байдаг.

Технологийн ялгаа:

ГШХО-ын улс орны хөгжилд үзүүлэх нөлөөллийг технологийн зөрүүний индексийн арга (Ли болон Лю, 2005), бүтээгдэхүүний технологийн агууламжид үндэслэх арга (Эдвардо Бронгстейн, 1996), бүтээмжид үндэслэсэн арга (Алмас Хэшимати 2010)-ыг ашиглан тодорхойлдог. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг авч байгаа орны техник технологийн хөгжил хэдий чинээ бага байна, гадаадын шууд хөрөнгө оруулалтын тус улсын өсөлтөнд үзүүлэх нөлөө төдий чинээ бага байдаг байна.

Технологийн зөрүүний индексийн аргаар босго оноог 12.6 гэж тодорхойлсон байдаг бөгөөд технологийн зөрүүний индекс 12.6-аас бага байвал тухайн оронд гадаадын шууд хөрөнгө оруулалт эерэгээр нөлөөлж байна гэсэн үг юм. Манай орны хувьд энэ үзүүлэлт нь 1990-2010 онуудад технологийн зөрүүний индекс 12.6-аас дээгүүр утгатай байгаа нь тухайн хугацаанд технологийн түвшнийхээ хувьд ГШХО-ын үр ашгийг бүрэн хүртэж чадаагүй гэсэн дүгнэлтийг өгчээ.

Ажиллах хүчний боловсролын түвшин

Онолын үүднээс үзвэл ГШХО орж ирэх нь эдийн засгийн өсөлтөд эерэг шууд нөлөөтэй бөгөөд эдийн засгийн хөгжилд орчин үеийн шинэ техник, технологи, хүмүүсийн ерөнхий мэдээлэл, мэдлэг, чадвар дээшлэх, ажлын байр бий болох (өрхийн орлого нэмэгдэх), дэд бүтцийн орчин сайжрах, татварын орлого өсөх зэрэг хөгжлийн үзүүлэлтээр дамжин дам нөлөөг үзүүлдэг. Хөрөнгө оруулалтын дээрх эерэг үр дүн бий болохын хэрээр гадаадын хөрөнгө оруулагчидын итгэл нэмэгдэж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх бөгөөд үүнтэй уялдан санхүүгийн зах зээл улам бүр тогтвортой болно. Гадаадад боловсрол эзэмшсэн мэргэжилтний тоо хэдий чинээ их байвал төдий чинээ гадаадын шууд хөрөнгө оруулалтын эерэг нөлөө өндөр байна гэж үздэг. Ажиллах хүчний боловсролын түвшний хөрөнгө оруулалтын шингээх чадварт нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан үзсэн судалгааг хийхэд ажиллах хүчний чанарын түвшинтэй заавал холбох хэрэгтэй болдог. Ажиллах хүчин бол хүн аливаа нэг хэрэгцээний өртгийг бий болгох явцад ашиглаж байгаа оюуны болоод биеийн хүчний чадвар юм.

Өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээр олон улсын хөрөнгө оруулалттай, ажилчин хүчний хөдөлмөрийн үнэлэмж өндөр хар зам тавих, барилга байгууламж барих, тохижилт хийх, тоног төхөөрөмж угсрах зэрэгт яагаад Монгол ажилчид ажиллахгүй гадаадын хятад ажилчид голлон ажиллаад байгаагийн шалтгаан нь хөдөлмөрийн нийлүүлэлтийн чанарын түвшин, ажиллах хүчний чанар хувийн хэвшлийн нөхцөлд гологдож байгаатай холбоотойг Монголын хүний хөгжлийн илтгэлд тэмдэглэсэн байна.

Иймээс ажиллах хүчний чанарыг өндөржүүлэхэд шууд хөрөнгө оруулалт нь мэргэжлийн өндөр түвшинг шаардах талаасаа ч, ерөөсөө боловсрол эзэмшээгүй байсан ч шууд хөрөнгө оруулалт нь ажиллах хүчний чанарыг өндөржүүлдэг гэж үздэг. Боренсзтай, Корковик, Ливэйжи, Эйлфейро нарын онолын үүднээс авч үзсэн ч ажиллах хүчний чанар өндөржиж бүтээмж өсч, орлогыг илүү ихээр бий болгож, ажиллах хүчний ШХО-ыг шингээх чадварыг нэмэгдүүлдэг болохыг тодорхойлсон байна. Хамгийн гол нь ШХО нь мэргэжил, мэргэшил олгох цаг хугацааг хэмнэдэг гэж үзжээ. Ажиллах хүчний чанарын өсөлт нь ШХО-ыг шингээх чадварыг нэмэгдүүлэх төдийгүй, бүтээмжийг өсгөх, олон улсын зах зээлээс шууд хөрөнгө оруулалтыг илүү олох, хүмүүс эрх чөлөөгөө эдлэх гол хүчин зүйл болдог байна.

Санхүүгийн хөгжил

Санхүүгийн тогтвортой байдал гэх ойлголт нь өргөн хүрээг хамардаг бөгөөд ОУВС болон улс орнуудын хувьд тэдгээрийн эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын орчин, банк санхүүгийн зах зээл, үнэт цаасны зах зээл болон бусад салбаруудыг төлөөлүүлэн авч үздэг. Аливаа улс орны санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь тухайн улс орны хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг байдаг. Улс орон болгон өөрийн онцлогоос хамааралтайгаар санхүүгийн тогтвортой байдлыг авч үздэг.

Манай орны хувьд санхүүгийн тогтвортой байдлыг эдийн засгийн орчин, олон улсын эдийн засаг үнийн орчин, хөрш орнуудын эдийн засгийн байдал, санхүүгийн салбарыг төлөөлүүлэн авах (манай орны хувьд санхүүгийн зах зээлийн 95.3 хувийг банкны салбар эзэлдэг) боломжтой. ОУВС-аас санхүүгийн системийн тогтвортой байдал, түүнийг хүчирхэгжүүлж хяналт тавих, үнэлгээ хийхэд туслах зорилгоор санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тооцдог болсон. Өнгөрсөн үеүүдэд гарч байсан олон улсын банк,

санхүү, эдийн засгийн хямралууд нь санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-аас тооцоолох шаардлагыг бий болгосон бөгөөд гишүүн орнуудын мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн жагсаалт болон тооцоолох аргачлалыг боловсруулан гаргасан байдаг. Үүний үр дүнд санхүүгийн тогтвортой байдлын 40 үзүүлэлтийг ОУВС-ийн удирдах зөвлөлд танилцуулан батлуулсан байдаг. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд нь тухайн улс орны санхүүгийн салбарын дүр зургийг харуулах бөгөөд олон улсад мөрддөг тул улс орнуудаар харьцуулалт хийхэд тохиромжтой гэж үздэг.

Гадаадын хөрөнгө оруулалт буурах шалтгаан


Дэлхий дахинд Хөрөнгө оруулалт буурч байгаа ч Монгол улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт нь гадаад хүчин зүйлээс хамааралгүйгээр дотоод хүчин зүйлээс хамаарч унаж байна.

Монгол улсын эдийн засгийн өсөлт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаас шууд эерэг хамааралтай байгаа нь уул уурхайн түүхий эд нийт экспортын 85%, нийт хөрөнгө оруулалтын 72,5%-ийг эзэлж байгаатай холбоотой юм.

Өөрөөр хэлбэл, Монгол улс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах замаар богино хугацаанд эдийн засгаа өсгөх, хөгжлийн гарц юм. Гэвч сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч -82,5%-иар буурсан үзүүлэлттэй гарсан нь хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай юм.

Популизм

Монголын эдийн засгийн өсөлт нь Гадаадын шууд хөрөнгө оруулалт тэр дотроо Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээтэй шууд холбоотой. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг 2009 оны 10 дугаар сарын 06-нд баталсанаас хойш эдийн засгийн өсөлт болон гадаадын хөрөнгө оруулалт огцом нэмэгдэж, улмаар 2011 онд оргил цэгтээ буюу 4,9 тэр бум долларт хүрсэн боловч 2011 оны сонгуулийн өмнөх жилийн УИХ-ын гишүүд болон



улс төрчдийн популист хөдөлгөөн, оюутолгойн болон уул уурхайн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд руу чиглэн хөрөнгө оруулалтын гэрээг дахин нягтлан авч хэлэлцэхээр болсон нь Монгол улсыг найдваргүй түншийн хэмжээнд дэлхий дахинд таниулж 2011 оноос гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсаар хасах үзүүлэлттэй гарч байна.

2017 оноос хойш Гадаадын хөрөнгө оруулалт өсөж байгаа ч улс төрийн тогтворгүй байдал, татвар, бусад эрх зүйн орчин, Rule of law буюу эрх зүйт төрийн орчин нь гадаадын хөрөнгө оруулагчид тогтвортой хөрөнгө оруулалт хийхээс татгалзах нөхцлийг бүрдүүлж байна.

Ялангуяа уул уурхайн салбарын популизм газар авч урт нэртэй хууль, Оюутолгойн гэрээ, дубайн гэрээ гэх мэт улс төрчдийн гадаадын хөрөнгө оруулагч нарыг гэрээгээ өөрчлөх, гэрээнд нэмэлт оруулах шахалт шаардлагууд, иргэдэд хүргэж байгаа популист амлалтууд хөрөнгө оруулагч нарыг үргээх, айлгах нөхцлийг бүрдүүлж байна.

Улс төрийн тогтворгүй байдал

Тухайн улс орны улс төрийн тогтворгүй байдал бий болох нь хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын бодит эрсдлийг бий болгодог. Оруулсан хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин өөрчлөгдөх, хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах, ажил зогсох, яриа хэлэлцээр ойлгомжгүй хэлбэрт шилжих зэрэг эрсдлүүдийг бий болгодог. Тиймээс хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын PESTLE (political, economic, social, technology, law, environment) шинжилгээг хийж үздэг. Эдгээрээс хамгийн эрсдлийг бий болгож байдаг нь улс төрийн орчин юм.

Монгол улсын хувьд Хүчтэй ерөнхийлөгчтэй парламентын засаглалтай улс юм. УИХ-ын засгийн газрын гишүүн бүрийг томилж, чөлөөлдөг. Монгол улс байнгын ажиллагаатай парламенттай болоод 25 жил өнгөрчээ. Анх 1990 онд 50 гишүүнтэй хуралдаж байсан Улсын бага хурлаас эхлээд өнөөдрийн УИХ хүртэлх хугацаанд 11 Засгийн газар үйл ажиллагаа явуулсан байх юм. Өөрөөр хэлбэл, статистик тоо баримтаас үзвэл нэг засгийн газрын дундаж хугацаа 2,3 жил байна. 25 жилийн түүхэнд 1992-1996 онд П.Жасрайн, 2000-2004 онд Н.Энхбаярын засгийн газрууд бүрэн эрхийнхээ хугацаанд ажиллаж чаджээ. Ялангуяа 1996 оноос хойш засгийн газрыг авч үзвэл 1,8 жил байна. Аливаа засгийн газар солигдоход дагаж төрийн албан хаагчид, дунд шатны удирдлагууд, яамдын газар, хэлтэс, агентлагийн даргаас авахуулаад солигдож байгаа нь улс төрийн тогтворгүй орчныг илэрхийлнэ.

2017 оноос 2024 оныг хүртэлх Засгийн газрын хувьд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ-ийн засгийн газар 4 жил ажиллаж чадсан боловч улс төрийн тогтворгүй байдлыг зөвхөн засгийн газартай холбон тайлбарлахаас илүүтэй, төрийн бодлогын талаар тогтвортой байдал алга байна. Монгол улс 1 өдөрт хууль тогтоомжийн асар их өөрчлөлт хийгдэж байгаа нь төрийн бодлогын тогтворгүй байдал хэр зэрэг байгааг илтгэнэ.

Түүхий эд commodity

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын дараагаас ашигт малтмалын гаралтай түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр хурдацтай өсөж 2012 онд оргил цэгтээ хүрсэн юм. Монгол улсын эксортын 85 хувийг эзэлдэг ашигт малтмалын гаралтай түүхий эдийн үнийн эерэг шок (өөрчлөлт) нь эдийн засагт эерэгээр нөлөөлсөн. Эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн Монгол улс мөчлөг дагасан төсвийн тэлэлтийн бодлого баримталснаар (Төсвийн зарлагыг нэмэгдүүлэх) 2013 онд Дотоодын Нийт Бүтээгдэхүүн өсөлт 17%-д хүрсэн билээ.

Уул уурхайн зах зээлийн төлөв байдалд Монгол улсын экспортын 4 гол бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть зах зээлийн төлөв байдлыг авч үзлээ. Учир нь Монгол улсын нийт экспортын 74 хувийг дээрх 4 түүхий эдийн экспорт эзэлж байна.

Дэлхийн зах зээл ашигт малтмалын гаралтай түүхий эдийн үнэ 2009 оноос тогтмол өсөлттэй байж 2011, 2012 онд оргил цэгтэй хүрсэн юм. 2012 оноос ашигт малтмалын гаралтай түүхий эдийн үнэ буурч өнөөдрийн байдлаар Алтны дэлхийн зах зээл дэх үнэ унц тутамд 1,095.8 (-2011 оноос 30,3%) ам.доллар, А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр 5,221.5 (2011 оноос -31.2%) ам.доллар, төмрийн хүдрийн үнэ 55.0 ам.доллар, нүүрсний үнэ 48,6 (2011 оноос 58.1%) ам.доллар болж буурчээ. Энэ нь нийлүүлэлт хэтийдсэн, эрэлт багассантай шууд холбоотой юм.

Түүхий газрын тосны үнэ наймдугаар сард 16 хувиар унасан бөгөөд гурав дахь сардаа унаж байгаа нь энэ юм. Энэ үнийн бууралт ОПЕК-ын их хэмжээний үйлдвэрлэл зорилтот байгаа давж гарсныг, Ираны цөмийн зэвсгийн мэдэгдэл болон Оросын үйлдвэрлэл уян хатан байгааг харуулж байна. Санхүүгийн хүчин зүйлүүд ч хөрөнгө оруулагчдыг эрсдэлтэй хөрөнгийн зах зээлээс гаргах, газрын тосны үнийг наад захын дарамтанд оруулах төлөвтэй байна.

АНУ дахь байгалийн хий наймдугаар сард 2.4 хувиар багассан нь эрэлт бага байгаа ч шинэ нийлүүлэлт үүсч буйтай холбоотой. Нүүрсний үнэ наймдугаар сард 2.5 хувиар унасан нь мөн л эрэлт бага байгаа, нийлүүлэт хэтийдсэнтэй холбоотой.

Зэсийн зах зээл 2014 онд 7 хувиар өссөн бол 2015 онд дэлхийн цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл 4 хувиар өсөх төлөвтэй байгаа бөгөөд 23.4 сая тоннд хүрч Хятадын электролитийн станцууд дахь чадамжаа ихэсгэхээр байна.

Баяжмалын ашиг тус өссөнөөр анхдагч цэвэршүүлсэн үйлдвэрлэл 6 хувиар, хаягдлын зах зээл үргэлжлэн хумигдах учир хоёр дагч үйлдвэрлэл 2 хувиар буурах төлөвтэй байна.

Металлын үнэ наймдугаар сад 3.3 хувиар унасан бөгөөд энэ нь гурав дахь сардаа унаж 2010 оноос хойш үргэлжлэн хамгийн доод түвшинд хүрч байна. Энэ уналт нь Хятадын хөрөнгийн зах зээлийн цаашдын тогтворгүй байдалтай холбоотой байгаа юм.

Хамгийн том уналт цайр болон никельд нүүрлэж тус бурдээ 10 болон 9 хувиар унажээ. Зэс болон хөнгөн цагааны үнэ тус бүрдээ 6 хувиар буужээ. Төмрийн хүдэр 8 хувиар өсчээ.

2014 онд ердөө 2.4 хувийн өсөлттэй байна гэж мэдээлэгдсэн дэлхийн уул уурхайн үйлдвэрлэл 2015 онд 19.5 сая тонн, 2016 онд 20.5 сая тонн болж тус бүр 5 хувь өсөх магадлалтай байна.

2016 онд дэлхийн цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл 2.5 хувиар өсч 25 сая тоннд хүрэх найдлагатай байна. 2014 онд ил тод хэрэглээ 7 орчим хувиар нэмэгдсэний дараагаар Олон улсын зэсний судалгааны баг 2015 онд дэлхийн ил тод цэвэршүүлсэн хэрэглээ зөвхөн 0.6 хувиар нэмэгдэнэ хэмээн найдаж байгаа. Гэвч Хятадын үйлдвэрлэлиийн эрэлтийн өсөлт 4.5-5 орчим хувьтай байх бөгөөд Хятад дахь ил тод хэрэгцээ 1 хувиар өснө гэх хүлээлттэй байна.

Өөрөөр хэлбэл, дэлхийн үлдэгдэл хэрэгцээ жигд хэвээр байна. 2016 онд ил тод цэвэршүүлсэн хэрэглээний өсөлт 3 орчим хувь байх бол Хятадын үйлдвэрлэлийн үндсэн хэрэгцээний өсөлт 5 хувь орчим байна гэж найдаж байна. Дэлхийн үлдсэн хэрэгцээ 2 орчим хувиар нэмэгдэх төлөвтэй байна.

2017 оноос БНХАУ-ын импортын бодлогод өөрчлөлт орж улмаар түүхий эдийн зах зээлийн эрэлт нэмэгдсэнээр уул уурхайн салбарт буцаж сэргэсэн билээ. Гэвч 2020 оноос Ногоон хөгжил, ногоон бодлого нь дэлхийн түүхий эдийн зах зээлийн үнэ буурах нөлөөллийг бий болгож байна. Харин 2024 онд судалгааг хийж байх явцад АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль болж Доналд Трамп гарснаар Уур амьсгалын өөрчлөлт, ногоон бодлого, бусад хэлэлцээрүүдээс гарахаа мэдэгдсэн нь эргээд түүхий эдийн зах зээлд сэргэлт авчирч байна. Цаашлаад одоогийн байдлаар түүхий эдийн зах зээлийн үнэ буурч байгаа хэдий ч өсөх хандлага ажиглагдаж байна.

Чиг хандлага. Газрын тосны үнэ өсч байгаа ч эрэлт суларч, нийлүүлэлт илүүдэх болсон зэргээс үүдэлтэй байгалийн хий болон нүүрсний үнийн уналт үргэлжилсээр байгаа юм (тус бүр 13 болон 4 хувиар буурсан). Эрэлт найдаж байснаас өндөр байгаа ч газрын

тосны зах зээл, ялангуяа АНУ хэт их нийлүүлэлт, маш их нөөцтэй хэвээр л байна. АНУ-ын нийлүүлэлтийн хэмжээ 11-р сард маш өндөр байсан ч түүнээс хойш 60 хувиар буурсан байна. Гэвч газрын тосны үйлдвэрлэл жилээс жилд өдөрт нэг сая барреллээр нэмэгдсээр байгаа юм. ОПЕК-ын үйлдвэрлэл үргэлжилсээр байх төлөвтэй ч зургадугаар сарын үйлдвэрлэл жилийн эхэн үеэс их буюу өдөрт 1.5 сая баррель газрын тос үйлдвэрлэж байна.

Нийлүүлэлт ихэсч, нөөц үлэмж хуримтлагдсанаас үүдэн эрчим хүчний бус бараа бүтээгдэхүүний үнэ 2015 оны хоёрдугаар хагаст 2 хувиар унасан буюу 2011 оны эхэн үеийн өсөлтийн гуравны нэгтэй тэнцэх хэмжээгээр унасан байгаа юм. Металлын үнэ буурахын зэрэгцээ металлын зах зээл одоо ч илүүдэлтэй хэвээр байна. Ялангуяа төмрийн хүдрийн үнэ 2011 оны гуравны хоёртой тэнцэх хэмжээгээр унаад байгаа юм.

Эрэлт багассанаас болж бордооны үнэ 4 хувиар унажээ. Энэ оны сүүлээр АНУ-ын сонирхлын түвшин өндөр байна гэсэн хүлээлт байсан ч хөрөнгө оруулагчдын эрэлт багассанаар үнэт металлын үнэ 2 гаруй хувиар унасан юм.


Түүхий эдийн чиг хандлагын хувьд газрын ховор элементийн зах зээл хүчтэй тэлж, Монгол улс ховор элементийн хувьд гол экспортлогч орнуудын нэгд зүй ёсоор орж байгаа нь Гадаадын шууд хөрөнгө оруулалт татах хандлагыг бий болж байна.

2020 оноос хиймэл оюун ухаан, блокчэйн, технологийн эрс хувьсгал нь эрчим хүчний нөөцтэй, эрчим хүч хямд эх үүсвэртэй улс орнуудад хөрөнгө оруулалт хийхээр хөрөнгө оруулагчид эрэл хайгуул хийх болсон ба улс орнууд БНХАУ, АНУ зэрэг гол тоглогчид бүгд хямд эрчим хүчний эх үүсвэрт анхаарал хандуулж байна. Нөгөө талаар Европын улс орнуудын эдийн засгийн хямрал нь үйлдвэрлэлийг огцом бууруулж, ногоон эдийн засгийн бодлого нь эцэстээ эдийн засгийн хямралд хүргэдэг тул татгалзах чиг хандлагатай байна.

Алсын төлөв ба эрсдэл. Хиймэл оюун ухаан, технологийн өөрчлөлтүүд ихээр нэмэгдэж, тэр хэрээр эрчим хүчний эрэлтийг бий болгож байна. Дэлхийн эдийн засгийн чуулганаас түүхий нүүрснээс татгалзсанаар түүхий нүүрс, газ зэрэг бүтээгдэхүүн

Девольваци

Төгрөгийн ханш сулралт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтанд үлэмж хэмжээгээр нөлөөлөхгүй ч бага хэмжээгээр нөлөөлж байна. Учир нь гадаад зах зээлд Монгол улсын гол хөрөнгө оруулалтын салбарын үнэ унасан. Нөгөө талаар төгрөгийн ханш унаснаар гадаадын хөрөнгө оруулагч нарын орлогын хэмжээг бууруулж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.



Гэвч төгрөгийн доллартай харилцах ханш нь бараа бүтээгдэхүүний экспортод эерэг нөлөөлөх боловч эдийн засгийн хувьд ДНБ-ний хувьд сөрөг нөлөөтэй юм. Монгол банкнаас хэт их мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байгаа нь девольваци бий болох үндсэн суурь бүрдэхэд хүргэж байна. Иймд цаашид мөнгө хэвлэлтийг зогсоох, эдийн засгийг агшаах нь гадаадын хөрөнгө оруулагчид орж ирэх таатай нөхцөл болно.

OLI (Owner, Location, Internalization)

Эзэмшил (Ownership)

Монгол улсад шууд хөрөнгө оруулалт хийхэд тухайн орон нутгийн хөгжүүлэх, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх зардал гаргах үүргийг гадаадын шууд хөрөнгө оруулагчид давхар хүлээдэг. Энэ нь орон нутгийн тухайн хөрөнгө оруулагчидтай өрсөлдөхөд саад болдог. Гадаадын шууд хөрөнгө оруулагчдын хувьд Монгол улсын орон нутгийн дэд бүтцийн хөгжил тааруу, нүүдэлчин соёл, малчидын амьдралын хэв маяг, соёл, ёс заншил нилээд бэрхшээл учруулдаг. Гэсэн хэдий ч дотоод хөрөнгө оруулалт хөгжөөгүй, дотоодын хөрөнгө оруулагчдын технологийн чадавхи дутмаг байдал нь гадаадын шууд хөрөнгө оруулагчдад давуу талыг олгодог.

Байршил (Location)

Үйл ажиллагааны байршлыг тодорхойлдог зүйл нь мэдээж хэрэг хөрөнгө оруулалтын шинж чанар болон зорилготой холбоотой байршлын давуу тал юм. Зарим үйлчилгээний салбарт хил хоорондын үйл ажиллагааны зардал их өндөр байдаг бөгөөд үүний улмаас хэрэглэгч улсад арилжааны төлөөлөл байх шаардлага гардаг. Зочид буудлын үйлчилгээ үүний нэг жишээ юм.

Үйлдвэрлэлийн зардлыг бууруулахын тулд үндэстэн дамжсан корпораци нь үйлдвэрлэлийн процессын янз бүрийн шат дамжлагыг өөр өөр улсуудад байршуулдаг. Монгол улсын хувьд геополитик болон гео эдийн засгийн хувьд хамгийн оновчтой байршилд байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах нэг хүчин зүйл юм. Гэвч үйлдвэрлэлийн зардлыг бууруулах гадаадын шууд хөрөнгө оруулалтын сонирхолыг дэд бүтэц орон нутагт хөгжөөгүй, эдийн засгийн хөдөлмөрийн идэвхитэй хүн амын бүтэц, хүн амын хэт төвлөрөл зэрэг хүчин зүйл сөрөг үр дагаварыг авчирч байна.


Зах зээлд өөрөө нэвтрэн орох (Internalization)

Орон нутгийн зах зээлд нэвтрэх, орон нутгийн иргэдтэй гэрээ хэлэлцээ хийхэд төвлөрсөн, нэгдмэл удирдлагын бүтэц, институтын хөгжөөгүй байдал зэрэг сөрөг үр дагаварыг авчирдаг. Энэ нь нэг талаасаа хэт брюкрат системд гадаадын шууд хөрөнгө оруулалт хийх, үр өгөөжийг амсахад эрсдэл учруулдаг. Иймээс гадаадын шууд хөрөнгө оруулагчид үйлчилгээний салбараас бусад салбарт өөрөө нэвтрэх аргыг сонгодоггүй.


ГУРАВДУГААР БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ИНДЕКС, БУСАД УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

Heritage Foundation

АНУ-ын Хэритэйж сангаас жил бүр гаргадаг Эдийн засгийн эрх чөлөөний индексийн гол үзүүлэлт болох Investment freedom үзүүлэлтээр Монгол улс 60.6 оноотой дэлхийд 76-д, азийн 39 улсаас 15-д бичигдэж байна.



Хамгийн муу үзүүлэлт бол Засгийн газрын шударга байдлын үзүүлэлт маш тааруу үзүүлэлттэй, дэлхийн авилгалд идэгдсэн улсуудын адил байгаа нь бид авилгал, хээл хахууль нь гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхэд том саад бэрхшээлийг учруулах эрсдэлтэй байна.



Дээрх индексүүдээс анхаарал хамгийн их татсан нь өмчийн эрхийн асуудалд бид маш доогуур, засгийн газрын шударга байдал маш хангалтгүй байна. Хэрэв та хөрөнгө оруулагч бол өмчийн эрхэд халддаг, Засгийн газар нь авилгалд идэгдсэн улс оронд хөрөнгө оруулалт хийх үү? Мэдээж үгүй байх. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дээрх орчин анхаарах, өмчийн эрхэд халдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.


Монгол улс нь дэлхий нийтэд 2 удаагийн үйлдлээр өмчийн эрхэд шууд халддаг гэдгээ нотолсон болно. Эхнийх нь Засгийн газарт эрх олгох тухай хуулиар Эрдэнэт үйлдвэр, дарханы төмөрлөг, хөтөл гэх мэт үйлдвэрүүдийг Засгийн газар нь шүүхийн шийдвэргүйгээр, социализмын үеийн буюу 1991 оны хуулиар шийдсэн нь маш том эрсдэлтэй улс гэхэд хүргэсэн.

Хоёр дахь нь мөн дээрх хуулиар Тавантолгой-д тогтоосон онц байдал юм.

Global economy institute

Глобал эдийн засгийн институтээс олон улсын гадаад хөрөнгө оруулалтын индексийг жил бүр гаргадаг. Энэхүү индексийг гаргахдаа ***Economic Fundamental*** (Macro performance, Openess to trade and FDI, Quality and structure of labor force, Physical infrastructure), ***Ease of Doing Business*** (Accounting and disclosure requirements, Costs of terrorism and crime, Tax burden, Costs of starting a business, Costs of enforcing contracts, Costs of resolving insolvency), ***Quality of Regulations/Regulatory Barriers to Investment*** (Extent and burden of regulation, Corruption, Transparency, Extent of controls on capital), **Rule of Law** (Legal infrastructure, Protection of property rights, Protection of investor rights) гэсэн үзүүлэлтүүдээр шинжилгээ хийж үнэлгээ гаргадаг юм.

Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтын индексээр 61 оноотой дэлхийн 183 орноос 78-д жагсаж байна. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын индексээр Монгол улс 2022 оноос хойш үзүүлэлт тус бүр дээр ухарч байгааг харж болно.




Дээрх үзүүлэлтээс үзвэл Хуулийн засаглал тэр дотроо хөрөнгө оруулагчийн эрхийн хамгааллын үзүүлэлт нилээд ухарсныг үзэж болно.



ДЭЛХИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА БА МОНГОЛ УЛС

Дэлхийн гадаадын шууд хөрөнгө оруулалт 2023 оныхоос даруй 0,24 триллион доллар буюу 16%-иар хөрөнгө оруулалт багассан үзүүлэлт гарчээ.



Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал буурсан нь хөрөнгө оруулагч, геополитикын өндөр эрсдэл, дэлхийн эдийн засгийн эмзэг, бодлогын тодорхойгүй байдал голчлон нөлөөлсөн байна. Шинэ хөрөнгө оруулалт нь голдуу томоохон хувьчлалууд байна.

2023 онд дэлхийн ГШХО 1.3 их наяд ам.доллар болж буурсан нь худалдаа, геополитикийн хурцадмал байдал, ялангуяа хөгжиж буй орнуудад нөлөөлж, долоон хувиар буурч, 867 тэрбум ам.долларт хүрч байгааг харуулж байна.

Олон улсын төслийн санхүүжилтийн хэлцлүүд 26%-иар буурсан нь хамгийн ядуу орнуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтад ноцтой сорилт үүсгэж, эдийн засгийн уналтад илүү өртөмтгий болгож байна.

Хямрал, протекционист бодлого, бүс нутгийн өөрчлөлтүүд нь худалдааны сүлжээ, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээг задалж, хөрөнгө оруулалтын урсгалын тогтвортой байдлыг алдагдуулж байгааг тайланд онцолжээ. Эдгээр сорилт бэрхшээлийг үл харгалзан санхүүгийн нөхцөл байдлыг хөнгөвчлөх, үндэсний болон олон улсын идэвхтэй хөрөнгө оруулалтын бодлогод тулгуурлан 2025 онд бага зэрэг өсөх боломжтой.


Зарим салбарууд, ялангуяа автомашин, электроник зэрэг дэлхийн нэмүү өртгийн сүлжээтэй холбоотой салбарууд, ялангуяа томоохон зах зээлд шууд нэвтрэх боломжтой бүс нутагт өсөлттэй байна. Гэсэн хэдий ч хөгжиж буй олон орон гадаадын хөрөнгө оруулалтыг татахын төлөө тэмцсээр байгаа нь эдгээр сүлжээнд оролцох оролцоог нь хязгаарладаг. Дэлхийн хөрөнгө оруулалтын ирээдүйг тодорхойлох сорилтууд болон тусгаарлагдсан боломжуудын аль алиных нь ландшафтын ерөнхий байдал ээдрээтэй хэвээр байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба газар зүй

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогш урсгал


Гадаадын шууд хөрөнгө оруулалт бүс нутгуудад ялгаатай буурсан байна. Шилжилтийн үеийн эдийн засагтай улс орнуудын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогш урсгал буурч байгаа хэдий ч хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын хувьд түүхэнд хамгийн оргил цэгтээ хүрчээ.


Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогш чиглэсэн урсгал нь нийт урсгалын 55 хувийг эзэлж байна. Латин америкт дотогш урсгал буурсан үзүүлэлт гарсан бол Африкт ямар нэг өөрчлөлт мэдрэгдээгүй, харин хөгжиж буй Азид гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогш чиглэсэн урсгал нэмэгдсэн үзүүлэлт гарчээ.



Гадаадын шууд хөрөнгө оруулалт өндөр хөгжилтэй улс орнууд 2%-иар буюу 24 тэр бум ам.доллараар буурсан үзүүлэлт гарчээ. Үүнд: АНУ-ын дотогш чиглэсэн урсгал голлон нөлөөлөв. АНУ-ын дотогш чиглэсэн урсгал 21 тэр бум ам.доллар болж буурсан байна. Мөн Европт 90%-иар буурчээ. Их британи умард ирландын нэгдсэн вант улс, Швейцари, Фянланд ГШХО-ын урсгал өссөн бол Ирланд, Бельги, Франц, Испанид буурчээ.

Азид ГШХО-ын урсгал 8%-иар буурч 621 тэрбум ам.долларт хүрсэн байна. Тухайлбал, Зүүн ази, зүүн өмнөд ази, Өмнөд азид бүгд өссөн дүнтэй гарчээ. БНХАУ-ын ГШХО-ын хэмжээ 163 тэрбум долларт хүрч (13.7 хувиар буурч) өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.





ГШХО Сингапур, Гонг Конг улсуудад өссөн бол Энэтхэг огцом буюу 22%-иар өссөн буюу 34 тэрбум ам.долларт хүрсэн нь анхаарал татаж байна. Гэсэн хэдий Баруун азид ГШХО-ын дотогш чиглэсэн урсгал нь бүс нутгийн аюулгүй байдлын улмаас 43 тэрбум ам.доллар буюу 4%-иар буурч сүүлийн 6 жилд ГШХО уналттай гарч байна. Энэхүү байдал цаашид ч үргэлжлэх хандлагатай байна.

Бүс нутгийн ГШХО-ын чиг хандлага нь геополитик, эдийн засгийн үзүүлэлт, бүс нутгийн аюулгүй байдлын хүчин зүйлс тодорхойлж байсан. Урт хугацааны хамтын ажиллагаа хүчин чармайлт, ихэнх нь хөрөнгө оруулагчдын эмчилгээний бодлого, хөрөнгө оруулалтын салбар нээх ба нийцүүлэх замаар бүс нутгийн бүлгүүдийн ГШХХО-ын урсгалыг нэмэгдүүлэх болно гэж таамаглаж байна.

ГШХО-ын дотогш чиглэсэн урсгалаар хэдийгээр АНУ-ын хувьд нилээд бууралт ажиглагдсан ч дэлхийд тэргүүлэгч улс орон хэвээр байна.


Гадаадын шууд хөрөнгө оруулалтын гадагш чиглэсэн урсгал

Латин америк болон карибын тэнгисийн улс орнуудын зарлага буурч харин хөгжиж буй орнуудын дунд Азийн улс орнуудын гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Анх удаа Азийн хөгжиж буй улс орнууд нийт хөрөнгө оруулалтын 1/3-ийг эзэлж, дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын бүлэг болжээ.


Figure I.10

The composition of financial flows to least developed countries differs from that of flows to other developing economies

Shares across categories of external financial flows, 2023
(Percentage)



Дэлхийн ТОП 20 улс орнуудын 9 нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай улс орнууд байна. Хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн арван жилийн хугацаанд их хэмжээгээр өссөн бөгөөд одоо дэлхийн гүйлгээний 1/3-ийг бүрдүүлж байна. Хамгийн том гадаадын шууд хөрөнгө оруулалттай эдийн засгийн хувьд Бразил, БНХАУ, Гонг Конг, Энэтхэг, БНСУ, Малайз, Мексик, Сингапур, Өмнөд Африк, БНХАУ-ын Тайвань муж орно.



Улс орнууд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулах, түүнд гадаад хөрөнгө оруулалт татах, эсхүл гадаад хөрөнгө оруулагчдыг татах, тэднийг улс орондоо бизнес эрхлэх боломжийг ханган улс орноо хөгжүүлэх гэсэн 2 үндсэн замаар хөгжиж байна. Үйлдвэрлэгч улс орны тоонд Энэтхэг, БНХАУ зэрэг улс орнууд орж байгаа бол гадаадын шууд хөрөнгө оруулагчдыг татан бизнес эрхлэх бүхий л боломжоор хангах замаар хөгжиж байгаа улс орнуудын тоонд Гонг Хонг, Сингапур зэрэг улс орнууд орж байна.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА СИНГАПУР

Сингапур нь Индонез болон Малайз улсын хооронд зүүн өмнөд азид орших хамгийн жижиг улс бөгөөд дэлхий дээрх олон улсын худалдааны хүчирхэг сүлжээгээрээ хурдацтай хөгжин цэцэглэж буй улсуудын нэг юм.

(2005 оны Хүн Амын Хөгжлийн Мэдээлэл)-ээр бодит Дотоодын Нийт Бүтээгдэхүүн жилийн дунджаар 6%-н өсөлттэй байсан бол Сингапурын хувьд 2003 онднэг хүнд ноогдох Дотоодын Нийт Бүтээгдэхүүн, Худалдан Авах Чадварын Харьцаа нь 24,481$ Ам.Доллар хүрсэн энэхүү Сингапурын эдийн засгийн огцом өсөлт нь улс орны эдийн засаг болоод нийгмийн баялагийг нэмэгдүүлсэн байна.Тухайн эдийн засгийн өсөлтийн ихэнхи нь гадны хөрөнгийн урсгалыг Сингапур руу татах бүтээгдэхүүн болон экспортыг нээлттэй худалдааны бодлогоор хэрэгжижээ. Мөн түүнчлэн Сингапурын засгийн газраас 1965 онд

эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшлийг сайжруулахын тулд гадаадын хөрөнгө оруулалт, экспортод тулгуурласан эдийн засгийн бие даасан бодлогыг баталжээ.

Энэхүү хуудаснаа Гадаадын шууд хөрөнгө оруулалт (FDI) ба Сингапурын эдийн засгийн өсөлтийн харилцан шүтэлцээг харуулна. 1-р Диаграммд ДНБ-ний жилийн өсөлт болон Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба Дотоодын Нийт Бүтээгдэхүүний харьцаа ямагт нягт хамааралтай байдгийг ДНБ-ний уналтанд Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба Дотоодын Нийт Бүтээгдэхүүн нь хоёул огцом бууралттай байснаас харах боломжтой төдийгүй 2001 онд ДНБ, Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь 5%-с илүүтэй уналтанд орж Сингапурын ДНБ-ний өсөлтөнд сөрөг үзүүлэлт тогтоогдсон байна.

Үүнээс гадна,1972-2006 оны хооронд Сингапур улсын эдийн засгийн хамгийн өндөр хувьтай дундаж үзүүлэлтийн харьцаа нь 5%-10% байсан бол 1985,1998,2001 онуудад эсрэгээрээ эдийн засгийн өсөлтийн сөрөг үзүүлэлтүүд гарсанд 1997 оны Азийн санхүүгийн зах зээлийн хямрал, 2001 оны АНУ-н хямрал томоохон нөлөө үзүүлсэн.

2-р Диаграммд, Аж үйлдвэрийн салбарын тэнцвэртэй байдал болон Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг Сингапурын ДНБ-д процентын хувиар илэрхийлсэн болно. Ерөнхийдөө, өмнөх түвшин буюу 1991 он хүртэлхийг бодвол ДНБ дэхь Аж үйлдвэрийн салбарын тэнцвэртэй байдал болон Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувь нь эрчимтэй өсөж байгаагийн сацуу худалдааны тэнцвэртэй байдал мөн Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувь нь 1972-2006 оныг хүртэл 4-7%-н хэмжигдэхүүнээр тодорхойлогдожээ.1997 оны Де Меллогийн судалгаагаар Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал нь Зүүн өмнөд азийн хэд хэдэн улсуудын ДНБ-д нийлүүлэгдэж байсан бол Латин Америкт 1980-1994 онуудадДНБ-дэкспортыг гүйцэж түрүүлсэн байна.1990-ээд оны Гадаадын шууд хөрөнгө оруулалтын эрс өсөлт нь ялангуяа хөгжиж буй орнуудад Гадаадын шууд хөрөнгө оруулалтанд төвлөрсөн томоохон судалгаа шинжилгээний суурь болж хүлээн авагч улсын ДНБ-д тулгуурласанэдийн засгийн идэвхитэй өсөлт болон хөрөнгө оруулалтын чиглэлд томоохон үүрэг гүйцэтгэх юм.Хөрөнгө оруулалт болон ДНБ-ны өсөлтийн учир шалтгаант холбоосын талаарх нарийвчилсан загварт 2 хэмжүүрийг авч үздэг. Үүнд, энэхүү загвар нь Шууд хөрөнгө оруулалт ба ДНБ-ний өсөлтийн хувийг эсвэл Хөрөнгө оруулалт болон ДНБ-ний бууралтыг тодорхойлдог. Иймд энэхүү судалгааны эрхэм зорилго нь Сингапурын ДНБ, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хоорондын бие даасан байдлыг шинжлэхэд оршино учир нь 1965 онд Их Британи Улсаас тусгаар тогтносноосоо хойш тэргүүлэх ,тогтвортой эдийн засгийн өсөлтөөрөө манлайлж байна. Тус судалгааны 2-р хэсэгт судалбарын товч хураангуй , 3-р хэсэгт хэрэглэгдэхүүн, арга зүй, 4-р хэсэгт үр дагавар,хэлэлцүүлэг, төгсгөл хэсэгт дүгнэлт зэрэг багтана.

Өнөө үеийн судалгаа

ГШХО болон ДНБ-д эерэг нөлөө байгаагүй хэмээн Карковик Левинь хоёр ГШХО, эдийн засгийн хөгжлийн хоорондын холбоосын талаарх судалгаан дээрээс дүгнэв. Мөн ГШХО, ДНБ-ын хооронд эерэг холбоо байлгахгүйгээр өөрчлөлт хийж Хансен Ранд хоёр Карковик болон Левинийн загвар тодорхойлолтыг улс орны чиг хандлага нэмэн боловсруулсан байна.

Тэд ГШХО-аас ДНБ-рүү шилжих хувь болон ДНБ-ий түвшний бүртгэл ба ДНБ-ий Грэйнжир нь ГШХО хоёр чиглэлийн жирийн байдлын хооронд маш хатуу холбоос олов. Жишээлбэл 31 орны 10 нь Ази (Сингапур орж байгаа), 11 нь Латин Америк болон үлдсэн 10 нь Африкийн орнууд байна. Чакраборти Басу(2002) хоёр нь Энэтхэг дэх ГШХО, үр дүнгийн өсөлтийн хоорондын жирийн байдлыг ажиглан 1974-1996 хүртэлх жил бүрийн мэдээллийг ашиглаж тэд Энэтхэгийн бодит ДНБ нь ГШХО Грэйнжир нөлөөтэй биш бөгөөд жирийн байдал нь бодит ДНБ-ээс ГШХО байдаг байна.

Ванг (2002) нь ямар төрлийн ГШХО эдийн засгийн хөгжилд нөлөөлөх вэ гэдэг зүйлийг 1987-1997 оны хооронд Азийн 12 улсын мэдээллийг ашиглан судалгаа хийж ГШХО-аар үйлдвэрлэлийн салбар нь эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлж ГШХО-ын ихэдсэн үйлдэлд нэмэгдэл болдог байна.

FDI нь дотоод хөрөнгө оруулалтыг бодвол эдийн засгийн өсөлтөнд илүү нэмэр оруулдаг.Blomstrom et al.(1994) нь тухайн орны хувь иргэний орлого хангалттай сайн байвал FDI эерэг нөлөөтэй байдаг гэж үзсэн.

Ericsson and Irandoust (2001) нь Дани, Финланд, Норвеги, Швед гэх дөрвөн OECD орнуудын мэдээллийг ашиглан FDI-н өсөлт ба бүтээмжийн өсөлтийн хоорондын холбоог судалсан юм. Уг зохиолчид Дани ба Финланд улсын хувьд FDI-н өсөлт ба бүтээмжийн өсөлтийн хооронд аливаа нэгэн харилцааг илрүүлж чадаагүй билээ. FDI эдгээр улсуудад нэвтрэх үеийн тусгай нөхцөл байдал нь уг гарздалгүй үр дүнд хүргэсэн байх бололцоотой гэж тэд нар санал болгосон юм.

De Mello (1999) нь 1970-1990 оны явцад OECD ба OECD-бус 32 орны цаг, серийн дугаар ба мэдээлэл хийгдхэд FDI-с үүдэлтэй өсөлт хэмээх таамаглалд нотолгоо олохыг оролдсон. Хүлээн авагчийн хөрөнгийн хуримтлал болон бүтээмжийн өсөлтөнд үзүүлэх FDI-н нөлөөг тэрээр таамаглаж байгаа юм.

Лиу, Бурридж ба Синклер (2002) нь Хятадын эдийн засгийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт ба наймаа гэх зүйлсийн хооронд урт хугацааны харилцаа байгаа үгүйг шалгасан юм. 1981- 1997 онуудын экспорт, импорт, FDI ба өсөлтүүдийн мэдээлэлүүдийг ашиглан FDI, өсөлт болон экспортын дунд харилцаа холбоо байгааг уг судалгаа илрүүлсэн. Уг судалгаанд FDI-GDP харилцааг оруулаагүй болно. Сонирхосон уншигч нар FDI ба өсөлт, FDI-н өсөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлийг de Mello(1997, 1999)-с олж авч болно.

Үр дагавар ба Хэлэлцүүлэг

Энэхүү өнөөгийн судалгаа нь 1976-2002 оны хоорондох үеийн жилийн ажиглалтын судалгааны мэдээллийн санг ашигласан бөгөөд бүх мэдээллийг Дэлхийн Банкны Мэдээллийн сангаас авч логарифмт шилжүүлж эконометрийн судалгааны хүчин төгөлдөр горимийг бий болгосноор эдийн засгийн өсөлтөнд эерэг үр дүн авчирна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь санхүүжилтийн цэвэр урсгал бөгөөд тогтвортой удирдлагын ашиг буюу хүүг авахын тулд (10% эсвэл хувьцаа эзэмшигчдийн хувьцаанаас ч ихийг) санхүүжүүлэгчээс илүүтэй эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй аж үйлдвэрээс эрэлхийлдэг.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА МУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

Энэ нь өмчийн хөрөнгө, орлогын дахин санхүүжилт,бусад урт хугацааны хөрөнгө болон богино хугацааны хөрөнгө зэргийн нийлбэр болоод төлбөрийн тэнцвэртэй байдлаас ихээхэн хамаардаг. Энэ тогтлолцоо нь эдийн засаг дахь санхүүжилтын цэвэр урсгал, АНУ-н өнөөгийн долларын мэдээллийн сан, нэг хүнд ноогдох ДНБ, (ДНБ нь хүн амыг жилийн дундажтай хуваан гаргадаг). ДНБ нь нийт үнийн дүнг эдийн засгийн харилцаанд оролцогч нийт иргэдийг хамруулан ямар ч бүтээгдэхүүний нэмэгдэл татваргүй төдийгүй ямар ч татаасгүйгээр тооцоолж гаргадаг.

Түүнчлэн, үнэт хөрөнгөнөөс ямар нэгэн суутгал, хямдрал, үнийн бууралт мөн байгалийн нөөцийн хасагдалтгүйгээр тооцдог. Мэдээллийн сан нь АНУ-н долларын тогтлолцоонд тогтмол ашиглагддаг.

Энэ судалгаа нь Сингапур улсын эдийн засгийн нэг хүнд ноогдох ДНБ болон Гадаадын Шууд Санхүүжилт хоорондын харилцан хамаарлыг Грэйнжир, Вектор Ауто Регрешин зэрэг аргыг ашиглан хийгдсэн. Сингапурын ДНБ дэхь эдийн засгийн өсөлт нь Гадаадын шууд санхүүжилтээс хамааралтай хэмээн Грэйнжир-н аргаар баттай нотолгоог гаргаж байгаа юм. Энэ нь Гадаадын шууд санхүүжилт болон ДНБ-ны хоорондын учир шалтгаант шууд уялдаа холбоог харуулахын зэрэгцээ Сингапур дахь Шууд санхүүжилт, ДНБ-ны хоорондын холбоост олон талт чиглэл байгааг ч мөн үгүйсгэх аргагүй. Дүн шинжилгээгээр, Сингапур улсын хөдөлмөрийн дээд бүтээмж болох чөлөөт аж үйлдвэрийн бүс, худалдааны байгуулал, татварын урамшуулал, дэд бүтцийн чанар болон технологийн нэвтрүүлэлт зэргийг эдийн засгийн дэвшилтэнд оруулах нь гадны хөрөнгийг хэрхэн татаж чадах вэ хэмээх энэхүү улсын гүйцэтгэлээс бүрэн хамааралтай. Худалдааны болон санхүүгийн хязгаарлалт тавих нь тухайн оролцогч улсуудад чиглэгдсэн гадны мөнгөн хөрөнгийн урсгалд саад учруулах нь бий.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нэг. Эдийн засгийн хөгжил, эдийн засгийн эрх чөлөөгөөрөө дэлхийд тэргүүлж буй улс орнуудыг харвал (Heritage Foundation, Fraser institute, Milken institute-ээс гаргадаг эдийн засгийн эрх чөлөөний индекс болон гадаадын хөрөнгө оруулалтын индекс) гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, худалдааны нээлттэй бодлогыг баримталж байна. Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексээр тэргүүлэгч Гонг Хонг, Сингапур зэрэг улс орнуудын хөгжлийн түүх, туршлагыг судалвал гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, худалдаа, хөрөнгө оруулалтын нээлттэй бодлого баримталснаар богино хугацаанд эдийн засгаа хөгжүүлж чаджээ. Ялангуяа, эдийн засгийн болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын индексээс үзвэл Монгол улс улс төрийн тогтвортой байдал, хуулийн засаглал (хүний эрх болон өмчийн эрхийн хамгаалал, шүүхийн тогтолцоо), дүрэм журмын чанарын асуудал хөндөгдөж байгааг анхаарах хэрэгтэй байна.

Хоёр. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь тухайн улсын эдийн засгийг богино хугацаанд хөгжүүлэхээс гадна. Тухайн улсын технологи, үйлдвэрлэл, инновацийг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлдэг зэрэг эерэг ач холбогдол өндөртэй байна. БНСУ болон Япон улсуудын технологийн хөгжил нь тухайн улс орнууд гадаадын шууд хөрөнгө оруулалт татах замаар инноваци болон хөдөлмөрийн хүн амын боловсрол дээшилж урт хугацаанд үйлдвэрлэгч орон болох эх үндсийг тавьсан байна. Өөрөөр хэлбэл, импорт нь экспортын эх үндэс болдог гэсэн онолын томъёоллыг баталжээ.

Гурав. Монгол улсын эдийн засагт нөлөөлөх гадаадын шууд хөрөнгө оруулалтын шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ нь Гадаадын шууд хөрөнгө оруулалттай хамааралтай грэнжирийн аргаар нотлогдож байна.

Дөрөв. Сингапур улс урт хугацаанд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах бодлого (1976 - оноос) баримталсан нь үр дүнгээ өгч Сингапур улсын хөдөлмөрийн дээд бүтээмж болох чөлөөт аж үйлдвэрийн бүс, худалдааны байгуулал, татварын урамшуулал, дэд бүтцийн чанар болон технологийн нэвтрүүлэлт зэргийг эдийн засгийн дэвшилтэнд оруулж чадсан байна.

Тав. Монгол улсын хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын OLI (Owner, Location, Internalization) загвараар дүн шинжилгээ хийж үзвэл. Хөрөнгө оруулалт хийх газар зүйн байршлын хувьд хамгийн тохиромжтой улс орон юм. Учир нь өмнөд болон хойд хөрш орнуудын улс төр болон эдийн засгийн бодлого хаалттай, том зах зээлтэй байхад хөрш орнуудтай хилийн нээлттэй бодлого баримтлан Ази, Европыг холбосон үйлдвэр, худалдааны транзит бүс болон хөгжүүлэх боломж Монгол улсад нээлттэй байна. Гэвч хүн амын соёл, уламжлал, стереотип, зах зээлийн эдийн засгийн мэдлэг, хандлага хоцрогдмол байдал нь гадаадын хөрөнгө оруулагчдын талаар сөрөг хандлагатай байх, эсэргүүцэх, үүн дээр тулгуурласан улс төрийн акциуд нь УИХ, Засгийн газар, орон нутгийн түвшинд өрнөж байгаа гэх мэт саад бэрхшээлүүд гадаадын хөрөнгө оруулагчид дөлөх шалтгаан болж байна.

Зургаа. Монгол Улсын эдийн засаг, ДНБ-ний өсөлт нь Оюутолгойн хөрөнгө оруулалттай шууд хамааралтай байгааг ДНБ-ний өсөлт болон Гадаадын хөрөнгө

оруулалтын графикаас харж болох юм. Өөрөөр хэлбэл, 2009 оны 10 дугаар сараас эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдэх эх үндэс болсон байна.

Долоо. Монгол улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах шалтгаан нь 2009 оныг хүртэл дэлхийн зах зээл, дэлхийн хөрөнгө оруулагчдын уналтаас хамааралтай байсан бол 2009 оноос сэргэж хөрөнгө оруулалт 4,9 дахин нэмэгдсэн ч улс төрийн тогтворгүй байдал, хуулийн засаглал, өмчийн эрхийн хамгаалалт зэргээс хамааран (өөрөөр хэлбэл, дотоод хүчин зүйлээс хамаарсан) гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ эрс буурч хасах руугаа ороод байна.

Найм. Дэлхийн хөрөнгө оруулалтын чиг хандлага буурч байгаа ч 2022, 2023, 2024 онуудад маш бага хэмжээгээр нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Түүн дотор Азийн улс орнуудын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай байгааг онцолж байна. Гэвч Монгол улсын хувьд гадаад секторын хүчин зүйл тийм таатай биш байх нь дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт, бууралттай шууд хамааралтай юм.

Ес. Дэлхийн зах зээл дээр commodity унах хандлагатайгаас үүдэн гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол (уул уурхайн) буурах хандлага ажиглагдаж байна. Хэдийгээр нийт хөрөнгө оруулалтын 69,4%-ийг худалдаа, нийтийн хоолны салбарт байгаа ч эдийн засагт гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалд нөлөөлөх нөлөөлөх 17,8% юм.

Арав. Монгол улсын хөрөнгө оруулалт шингээх чадвар дутмаг байна. Өөрөөр хэлбэл, Монгол улс нь технологийн хөгжлийн индексээр бусад хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад хоцрогдмол байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийхдээ технологийн шинэчлэлийг хийх, улмаар тэдгээр техник, технологийг хэрэгжүүлэх гадаад боловсон хүчний асуудлыг шийдвэрлэх зэрэг хүндрэл үүсч байна. Хүний нөөцийн чадавхийн хувьд Монголчууд гадаадад сургууль төгсөгчид эрс нэмэгдэж байгаа ч гүйцэтгэл, инженерийн (техник, технологийг нэвтрүүлэх) боловсон хүчний дутмаг байдал ажиглагдаж байна.

Арван нэг. Динамик макро эдийн засгийн гадаадын шууд хөрөнгө оруулалтын онол болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал ба валютын түвшний өөрчлөлтийн харилцан холбоог шинжилж гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ханшийн өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах хэрэгсэл гэж үздэг. Дээрх үзүүлэлт ч мөн адил Монгол улсын валютын ханш, алтны нөөц болон валютын нөөцтэй шууд уялдаж байгааг судалгаанаас харж болох юм.

Арван хоёр. Гадаадын шууд хөрөнгө оруулалт шингээх болон нэвтрэх гол хүчин зүйл нь тухайн улс орны санхүүгийн зах зээлийн хөгжил юм. Монгол улс 25 жилийн түүхэнд санхүүгийн зах зээл одоог хүртэл хөгжиж чадаагүй байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадваргүй байгааг, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах нэг хүчин зүйл болж байна.

Арван гурав. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бусад салбарууд түүн дотроо Хөдөө Аж Ахуйн салбарт хандуулах, түүнтэй холбоотой дэд бүтцийн хөгжил байхгүй байгаа нь ажиглагдаж байна. Түүн дотроо мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг татахад

дэлхийн эрүүл мэндийн стандарт, халдварт өвчний хамгаалалт болон нүүдлийн соёл иргэншил сөрөг үр дагаварыг авчирч байгааг гадаадын шууд хөрөнгө оруулалтыг статистикаас харж болох юм.

ЗӨВЛӨМЖ

1. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүний эдийн засгийн болон бусад ач холбогдол, үр өгөөжийн талаар иргэдийн ойлголт, боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай байна. Ялангуяа мэдээлэл дутмаг орон нутгийн иргэдийг чадавхижуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.
2. Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индексээр тэргүүлж буй улс орнуудын хөрөнгө оруулалтын бодлого, худалдааны нээлттэй бодлогыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
3. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын шингээх чадварыг сайжруулах. Түүн дотроо технологийн, боловсон хүчнийг бэлтгэх чиглэлд түлхүү анхаарал хандуулах шаардлагатай байна.
4. Гадаадын хөрөнгө оруулалт болон ДНБ-ний өсөлт, эдийн засгийн өсөлт Грэнжир шалтгаантай учир хуулийн засаглал, түүн дотроо өмчийн эрхийн асуудлыг хамгаалах, шүүхийн оновчтой тогтолцоо, арбитр болон шүүхийн тогтолцоонд олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэглэх зэрэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.
5. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлагатай байна.
6. Улс төрийн намуудын тогтвортой байдал, засгийн газрын тогтвортой байдлыг хангах чиглэлд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага гарч байна.
7. Монгол улс төгрөгийн ханшаа унагаахгүй байх, девольвацийн бодлого баримтлахгүй байх тал дээр анхаарч, төгрөгийн хэвлэлтэнд хяналт тавих эрхийн иргэний нийгэм, мэргэжлийн зөвлөлд (банкуудад) шилжүүлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээр

1. Эдийн засаг санхүүгийн салбарын тойм, 2015 он, 2-р улирал, Монгол банк
2. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2023, 2024, Үндэсний Статистикийн Газар
3. Статистикийн Блютень, 2015 оны 08 дугаар сар, Үндэсний Статистикийн Газар
4. 2024 оны эдийн засгийн тойм, Дэлхийн банк
5. Судалгааны ажил, товхимол 6, Монгол банк
6. Судалгааны ажил, товхимол 9, Монгол банк
7. Макро эдийн засгийн болон аж байдлын үзүүлэлтээр хийсэн хүчин зүйлийн судалгаа, 2010 он, Доктор Б.Батмөнх
8. 2015 оны Нэгдсэн Төсвийн Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хийсэн тойм дүгнэлт, 2015 он, Нээлттэй Нийгэм Хүрээлэн

Англи хэл дээр

1. IMF Country Report No. 24/109
2. Attracting investment in tourism, 2006, Tanzania’s investment outreach program, World Bank Group, MIGA
3. Foreign direct investment in Central Asian and Caucasian economies: policies and issues, Policies and strategies for the promotion and attraction of the FDI in less developed economies in transition.
4. World Investment Report, 2024, UNCTAD
5. http://www.heritage.org/index/
6. Ing. Tomoš Dudoš, PhD, Main Theories of FDI
7. worldbank.org/Documents/PapersLinks/2547.pdf
8. Ozawa Terumato, 2007, Professor Kiyoshi Kojima’s contributions to FDI theory, working paper.
9. Vintila Denisia, 2010, FDI Theories: An overview of the main FDI theories